

**ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 5 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-52

- 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/** 7-25
 - 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/** 25-52
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын
5 дугаар сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 56 гишүүнээс 29 гишүүн хүрэлцэн ирж, 51.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 03 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Ж.Баясгалан, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа, Б.Чойжилсүрэн, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Батсуурь, Х.Болормаа, П.Ганзориг, М.Мандхай, Ч.Номин, Д.Пүрэвдаваа, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Сайнзориг, М.Энхцэцэг;

Тасалсан: Ц.Баатархүү.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төсвийн хүрээний хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Монгол Улсын төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Өргөдлийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Хүний хөгжил, нийгмийн

бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа нар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ж.Ганбаатар, Л.Гантөмөр нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх

- нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2027 онд “36,493.4 тэрбум төгрөг” гэснийг “34,318.8 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “31.9” гэснийг “30.0” гэж, 2028 онд “38,644.0 тэрбум төгрөг” гэснийг “36,355.9 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “30.4” гэснийг “28.6” гэж, 2029 онд “40,444.7 тэрбум төгрөг” гэснийг “39,596.2 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “28.6” гэснийг “28.0” гэж;

- нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2027 онд “32,495.4 тэрбум төгрөг” гэснийг “26,316.7 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “28.4” гэснийг “23.0” гэж, 2028 онд “34,827.4 тэрбум төгрөг” гэснийг “27,963.6 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “27.4” гэснийг “22.0” гэж, 2029 онд “36,908.5 тэрбум төгрөг” гэснийг “31,110.6 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “26.1” гэснийг “22.0” гэж;

- ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/ 2027 онд “5.8” гэснийг “6.3” гэж, 2028 онд “6.0” гэснийг “6.5” гэж, 2029 онд “6.3” гэснийг “6.0” гэж;

- Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин 2027 онд “7.0” гэснийг “6.5” гэж;

- Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 2027 онд “57,114.9” гэснийг “51,403.4” гэж, 2028 онд “63,610.1” гэснийг “57,249.1” гэж тус тус өөрчлөх, эдгээр өөрчлөлтүүдтэй уялдуулан эдийн засгийн бусад үзүүлэлтэд нөлөөлөх нөлөөллийн тооцооллыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 29

Бүгд: 31

6.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төсвийн хүрээний хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Х.Булгантуяа, Б.Жавхлан, Х.Ганхуяг, Г.Ганбаатар, Г.Очирбат, Б.Түвшин нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах, үүнтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр үг хэлж, Байнгын хорооны дарга Н.Наранбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 18
Бүгд: 33
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"15.2.1.энэ хуулийн 15.3-т заасан нөхцөл, шаардлага хангасан албан татвар төлөгчийн тухайн улиралд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн татварын 20 хүртэл хувийг буцаан олгох бөгөөд иргэний дотоодод үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтад төлсөн албан татварыг 100 хүртэл хувийг буцаан олгох. Өргөн хэрэглээний хүнсний барааны жагсаалт, хэрэгжүүлэх хугацаа, тайлагнах журмыг Засгийн газар батална.

Жич: Өргөн хэрэглээний хүнсний барааны жагсаалтад согтууруулах ундаа, тамхи, ресторан, нийтийн хоол, түргэн хоол болон хүргэлтийн үйлчилгээний худалдан авалтыг хамруулахгүй байхаар журамд тусгана." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 22
Бүгд: 33
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Хоёр.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн, Х.Булгантуяа, Б.Жавхлан нарын тавьсан асуултад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан хариулж, тайлбар хийв.

Н.Наранбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмсүгэй:

"1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн "мэдэгдэл, түүний нэмэлт өөрчлөлтийг" гэснийг "мэдэгдлийг" гэж өөрчилсүгэй." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 19
Бүгд: 34
44.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн "7.5 дахь хэсгийн "түүний нэмэлт, өөрчлөлтийг", "төсвийн тодотголын" гэснийг тус тус хассугай" гэснийг "7.5 дахь хэсгийн "төсөл, төсвийн тодотголын" гэснийг хассугай" гэж өөрчилж, мөн зүйлийн дугаарыг "2" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 20
Бүгд: 34
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын "дэмжсэн" санал "эсрэг" гарсан тул хуралдааны тэмдэглэлд саналаа дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 44.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хамтарсан хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 57 минут үргэлжилж, 56 гишүүнээс 34 гишүүн хүрэлцэн ирж, 60.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хороодын ирц 51,8 хувьтай бүрдсэн тул 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг.

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Байхгүй бол хэлэлцэх
Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Пүрэвдорж нарын гишүүдийн өргөн барьсан. Болчихсон уу.

Н.Наранбаатар: Үргэлжлээд Төсвийн байнгын хороо хуралдах юм.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын хамт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод хүргүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын байнгын хороод 2026 оны 5 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж, санал, дүгнэлтээ ирүүлсэн байна. Одоо Байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг танилцуулъя.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Анар танилцуулна. Анар гишүүний микрофоныг өгье.

Ч.Анар: Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдөр нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод, бусад Байнгын хороонд тус тус шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуугаагүй бөгөөд зарчмын зөрүүтэй санал гаргаагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Анар гишүүнд баярлалаа. Дараа нь Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ундраа танилцуулна. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг танилцуулна.

П.Батчимэг: Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний

мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод, бусад Байнгын хороонд тус тус шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасныг баримтлан дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг 2027-2029 онд хөдөө аж ахуйн салбарыг хэрхэн төсөөлж байгааг тодруулж, ирэх 3 жилд болзошгүй зудын асуудлыг урьдчилан тооцоолж, хариу авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Замира жижиг, дунд бизнесийг дэмжих хүрээнд гадаадын банкны салбарыг Монгол Улсад байгуулах, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, аялал жуулчлалын салбарыг дэмжих бодлогын хүрээнд Астана-Улаанбаатар чиглэлийн нислэгийн маршрутад Баян-Өлгий аймгийг багтаах, Улсын Их Хурлын гишүүн Мандхай төсвийн хүрээний төсөлд ирэх оны төсвийн нийт зардлын хэмжээг нэмэгдүүлсэн эсэх тооцоолол хийснээр ядуурлын түвшнийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг эдийн засгийн бодит үр дүнг хэрхэн төсөөлж байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнийн өсөлт, махны үнийг тогтворжуулах хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байгааг анхаарах, газрын тосны экспортоос олсон орлого улсын төсөвт хэчнээн төгрөг бүрдэж байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Батчимэг гишүүнд баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу танилцуулна.

Ч.Лодойсамбуу: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн

нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг эрхлэх асуудлынхаа хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, түүний дотор тус хуулийн гадаад зээллэг, ашиглалттай холбоотой заалтад өөрчлөлт оруулах эсэх, төсвийн бодит байдал ямар байгаа талаар, өрийн төлбөрийн хүндрэл бий болгох эрсдэл байгаа эсэх, гадаад зээлийн ашиглалттай холбоотой 2 хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэсэн эсэх, Сэлбэ дэд төв төсөл зогссон эсэх, тус төслийн санхүүжилт, гүйцэтгэгч компаниудын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл хэрэглээний үнийн өсөлт 2027 онд 7 хувь, 2028 онд 6, 2029 онд 5 хувь байна гэж тооцсон боловч бодит байдалд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт цаашид ч өсөх хандлагатай байгаа нөхцөлд тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулан нэмэх хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангах талаар, мөн ахмад настнуудын тэтгэврийн орлого зөвхөн хувь хүний хэрэглээнд бус өрхийн амьжиргаа, зээл, суурь зардлын гол эх үүсвэр болж байгааг харгалзан үзвэл ирэх онд тэтгэврийн хэмжээг ямар аргачлалаар хэдий хэмжээгээр нэмэгдүүлэхээр тооцоолж байгаа талаар, инфляц төлөвлөснөөс давж өсөх эрсдэлтэй нөхцөлд төсөвт шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлэхээр төлөвлөж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа Оюутолгой компани хэдий үеэс ААНОАТ төлж эхэлсэн талаар, мөн ААНОАТ-ын орлогын өсөлтийг 10 хувьд хадгална гэсэн төсөөлөлд тус компанийн татварын орлого хэдэн хувийн нөлөө үзүүлж байгаа талаар, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж Ирээдүйн өв санд төвлөрч буй уул уурхайн орлогын тодорхой хэсгийг өнөөгийн ахмадын тэтгэврийн нэмэгдэл, шинэчлэл болон баялгийн шударга хуваарилалтад ашиглах талаар, Засгийн газар ямар бодлого баримталж байгаа талаар асуулт асууж, хариулт авсан.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт, цалин, тэтгэврийн нэмэгдлийг төсвийн алдагдал гэх шалтгаанаар хязгаарлаж байгаа атлаа 2026 оны хөрөнгө оруулалтын 11 их наяд төгрөгийн багцаас 3 их наяд төгрөгийг зөвхөн барилга байгууламжид зарцуулахаар тусгасан нь бодлогын хувьд хэр оновчтой талаар, мөн үр ашиг багатай хөрөнгө оруулалтыг танаж, уг эх үүсвэрийг иргэдийн бодит орлогыг дэмжих чиглэлд шилжүүлэх боломж Засгийн газарт байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жавхлан 2 жилийн өмнөх байдлаар Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 208 хуулийн 1080 заалтаар салбар бүрийн төсвийн зардлыг хуульчилсан нь төсвийн уян хатан байдлыг хязгаарлаж байгаа тул эдгээр хуулийн давхардал, үр ашиггүй зардлыг дахин нягталж, төсвийн шинэчлэл хийх талаар, Засгийн газрын бодлого төлөвлөгөө ямар байгаа эсэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчаас асуулт асууж, хариулт авсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Лодойсамбуу гишүүнд баярлалаа. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар танилцуулна.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2026 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39, 64 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Монгол Улс болон ОХУ-ын хилийн хамтран шалган баталгаажуулалтын ажлын явц, Засгийн газраас Улсын Их Хуралд бизнес хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлээр өргөн барихаар боловсруулж байгаа хуулийн төслүүд, зөрчлийн мэдээллийн системийг ашиглалтад оруулсан ажлын явц, үр дүнгийн талаар, аймаг, сумдын цогцос, хадгалах байрны нөхцөл байдал, хар тамхи, донтолттой тэмцэх үйл ажиллагааны төсвийг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал Шүүхийн тухай хуулийн Хууль зүйн байнгын хорооноос хянасан шүүхийн төсвийг бууруулахгүйгээр жилийн төсвийн төсөлд тусгах, шинээр байгуулагдсан Хүүхэд, гэр бүлийн шүүхийн төсөв болон Ази, Номхон далайн хүний эрхийн сургалт судалгааны төвийг байгуулахад шаардагдах төсвийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг Хууль зүйн байнгын хорооны хууль зүйн салбарын байгууллагуудын урсгал зардал нэмэгдэж байгаа эсэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын багц хуулийн төсөл батлагдсанаар төсвийн төсөөллийн тооцоололд нөлөөлөх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж Цагдаагийн мөрдөн байцаагчийн цалинг нэмэгдүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд хууль зүйн салбарын байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн хөрөнгө оруулалт, урсгал зардал, саналыг төсвийн төсөөлөлтэй хэрхэн уялдуулдаг талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүнд баярлалаа. Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Золжаргал танилцуулна.

Ж.Золжаргал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Өргөдлийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтын дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл Монгол Улсын 2026 оны төсөвт эмч, багш нарын цалинг боломжийн өндөр хувиар нэмэгдүүлэхээр баталсныг дурдаад, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд дээрх 2 салбараас бусад салбарын 40 гаруй мянган төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх асуудлыг хэрхэн тооцож тусгасан талаар, мөн Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор тэтгэвэр тогтоох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тэтгэвэр тогтоолгосон хугацаанаас хамааруулан олон шатлалтай тогтоосон нь алсдаа тэтгэврийн зөрүүг багасгах асуудлыг улам хүндрүүлэх нөхцөл үүсэхээр байгааг хэрхэн тооцож, тэтгэврийг нэмэгдүүлэхээр төсөлд тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хуулийн төслийг боловсруулахдаа жирийн хөдөлмөр эрхэлж байгаа албан хаагчдын төлөөллийн байгууллагуудтай зөвшилцөж, тэдний саналыг тусгасан эсэх, хуулийн төслийн 5 дугаар бүлгийн хавсралт гэсний газрын тосны боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нийт хариуцагч болон төсөл эхлэх огноо, бүс нутаг, нийт төсөвт өртгийн талаар, мөн хуулийн төсөлд экспортолж буй нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ, түүнийг хэрхэн тооцож, төсөөлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоол хөтөлбөрт дунд болон ахлах ангийн сурагчдыг хамруулах зардал, санхүүжилтийг хэрхэн төлөвлөж төсөлд тусгасан талаар, мөн хөрөнгө оруулагчдын анхаарлыг татахуйц ямар шинэ төсөл, хөтөлбөр төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн төсөөлөлд тусгагдаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах ядуурлыг бууруулах хамгийн зөв гарц бол боловсролын чанарыг сайжруулах асуудал бөгөөд хууль, төсөлд боловсролын салбарын чанар, хүртээмжийг тэлэх, багш нарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, тэднийг бэлтгэх, давтан сургах, хомсдолыг арилгах талаар ямар бодлого баримталж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг Өргөдлийн байнгын хороонд хандан иргэдээс амьдрах орчин, нөхцөлөө сайжруулах, төрийн үйлчилгээ, хүний эрх зөрчигдөж байгаа талаар шударга бус байдал, татвар, шимтгэлийг бууруулах, инфляцыг тогтворжуулах зэрэг амьжиргааны асуудлуудаар өргөдөл, гомдол их ирүүлж байгаа бөгөөд Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын багц хуульд оруулахаар төлөвлөсөн өөрчлөлтийн бодлого нь Монгол Улсын 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн төсөлтэй уялдсан эсэх, улсын төсвийн суурь тэнцлийг хуульд заасан

хамгийн дээд хязгаар буюу ДНБ-ий 2 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай байхаар тооцоолсон нь хэрэгжих боломжтой эсэх талаар, мөн ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд дунд, ахлах ангийн сурагчдын хоолны төсвийг төсөлд заавал тусгахад анхаарах талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Золжаргал гишүүнд баярлалаа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ундраа танилцуулна.

А.Ундраа: Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг нийгмийн даатгалын орлогыг хэрхэн төсөөлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний өр зээл хэзээ төлөгдөж дуусах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч байгаа зарим хувийн хэвшлийн эмнэлгүүд иргэдээс давхар үнэ өндөр төлбөр авч, гэрээнд заасан буцаан олголтыг бүрэн олгохгүй байгааг анхаарах, аймаг, орон нутгийн улсын эмнэлгийн урсгал зардлыг нэмж тусгах эсэх, эмч, эмнэлгийн ажилтнуудын илүү цагаар ажиллаж авсан нэмэгдэл хөлснөөс татвар ногдуулж байгаа нь ямар үндэслэл зохицуулалттай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан хуулийн төсөлд хэрэглээний үнийн өсөлтийг их өндрөөр төсөөлж өргөн барьж байгаа нь бодит байдалд нийцдэггүй, мөн төсөлд инфляцын төсөөллийг ОУВС болон Дэлхийн банкнаас гаргасан тооцоололд үндэслэсэн эсэх, цалин, тэтгэвэр, тэтгэмж нь инфляцтайгаа хэр уялдсан талаар, хөгжлийн

бэрхшээлтэй иргэдэд олгогдож буй нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь амьжиргааны доод түвшнээс бага байгааг шийдэх шаардлагатай, хүн ам, зүйд чиглэсэн бодлого, арга хэмжээ түлхүү туссан боловч нийгмийн халамж зорилтот бүлэгт чиглэсэн бодлого бага тусгагдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төслийн агуулга, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж бусад хуулийн төсөлтэй дагалдуулан хэлэлцүүлэх бус бие даасан байдлаар хэлэлцүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа -Нара өнөөдрийн байдлаар Засгийн газрын гадаад болон дотоод өр хэд байгаа, үүнээс иргэн бүрд ноогдож буй нийт өр ДНБ-ий өсөлттэй зэрэгцэн Засгийн газрын өрийн хэмжээ тэлж байгаа нь зөв эсэх, ахмадын тэтгэвэр, хүүхдийн мөнгөн тэтгэмж болон цалинтай ээжийн тэтгэмжийг нэмэгдүүлэх асуудлыг төсвийн төсөөлөлд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн хүн амын өсөлт, гэр бүл салалт, мөн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар ямар үйл ажиллагаа тусгагдсан талаар, залуу гэр бүлийг дэмжих бодитой төсөв байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа ахмадын тэтгэврийг индексжүүлэх, тэтгэврийн зөрүүг арилгах чиглэлээр тодорхой ажил арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх, Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ДНБ-д эзлэх хувь хэмжээг 25 хувьд хүргэх зөвлөмж өгсөн боловч уг зорилтот түвшинд хүрч чадахгүй байгаа шалтгаан, хувийн тэтгэврийн сангийн асуудал, зарим Монгол Улсад үйлдвэрлэсэн дотоодын хүнсний бүтээгдэхүүн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчилдэг хэдий ч дамжуулан борлуулагч гэсэн хуульд байхгүй нэрээр нэмэгдсэн өртгийн албан татвар авч байгаа асуудлыг авч хэлэлцэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах төслийн баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд боловсролын асуудал яагаад тусгагдаагүй талаар, боловсролын салбарт оруулж буй сүүлийн 2 жил болон энэ жилд оруулсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын харьцуулалтын талаар, 1 хүнд ноогдох ДНБ-ийг өсгөх чиглэлээр ямар арга хэмжээ хийгдсэн, импортын бүтээгдэхүүний үнэ савлагаатай байгаа цаг үед эдийн засгийн бүтцийг хэрхэн төрөлжүүлэх, импортыг орлох гол нэрийн бүтээгдэхүүнийг дотооддоо дэмжиж хөгжүүлэх талаар ямар төсөөлөл байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун Тогтвортой байдлын зөвлөл болон аудитаас өгсөн зөвлөмжийг бодитоор хэрэгжүүлж ашигладаг эсэх, төсөлд тусгагдсан төсвийн орлогын өсөлттэй тооцоололд жижиг аж ахуйн нэгжийг оруулсан эсэх, хэрэглээний үнэ буурах төсөөллийг хэрхэн тооцсон талаар, төсөл төлөвлөгөөнд тусгагдаагүй үлдсэн ажлын талаар, нэмэгдсэн өртгийн албан татварын бодлогын үр шим нь ямар салбар аж ахуйн нэгжүүдэд ямар байдлаар хүрч нөлөөлж байгаа талаар, татварын тогтолцоог үе шаттайгаар олон улсын стандартад нийцүүлэхээр тусгасан нь нөхцөл байдал эдийн засгийн чадавхтай хэр нийцэж байгаа талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авсан бөгөөд зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Ундраа гишүүнд баярлалаа. Байнгын хороодын санал, дүгнэлтийг танилцуулж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл 1 зүйлтэй. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Төсвийн Ерөнхийлөгчийн захирагчаас асуулт асууж болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Жавхлан гишүүнээр, Гантөмөр гишүүнээр тасаллаа. Жавхлан гишүүн. 1 дүгээр зүйлтэй холбоотой. Зарчмын зөрүүтэй санал арай болоогүй.

Б.Жавхлан: Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуух гэсэн юм. 2 зүйл л асуугаадахъя. Энхбаяр сайд аа, энэ нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,7 их наяд гээд энэ тоон дотор 2026 оны орон нутгийн төсвөөс үлдэгдлийг нь санхүүжүүлэх зарлагын төсөвт тусган баталж хэрэгжүүлэх гээд 57.3 дээр ийм заалт байдаг юм. Төсвийн тухай хуульд. Тэгэхээр энэ 1,7 их наяд дотор чинь хэдэн хувь нь орон нутгийн зардал байгаа вэ. Энийгээ яаж харж байна вэ гэдгийг тодруулъя.

Мөн Засгийн газрын өрийн нийт хэмжээгээ нөгөө уг нь цаашаа тогтвортой ингээд 45 хувь дээрээ барьчихъя гээд ингэж явж ирсэн. Энийгээ буцаагаад 50 болгочхож байгаа юм байна. Тэгэхээр энэ бол хязгаар л даа. Хязгаар. Гэхдээ нөгөө 45-аас дээш нь давуулаад 50 гээд тавьчихаар 45 давуулж хэрэглэх юм байна дор хаяж гэдэг ийм мессеж эдийн засагт өгөөд байна л даа. Гадаад өр маань өөрөө. Тэгэхээр энэ 2 дээр хариулт өгөөч.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя. 5 номер.

Ж.Энхбаяр: Засгийн газрын өр 50. Одоогоос жоохон нэмж байгаа учир шалтгаан гадаад зээлийнхээ өр, ашиглалтыг сайжруулна. Хууль өргөн барьчихсан байгаа. 2 том төслөө явуулна. Хэрэв 2 том төслийг гадуур гаргах юм бол бид нар эдийн засгаа идэвхжүүлэх гол орон зайг бол гадаад зээлийн ашиглалтыг нэмж байж л эдийн засагт өнөөдөр учраад байгаа хүндрэл бэрхшээлийг даван туулах гол хөшүүрэг болгож ашиглана л гэсэн агуулгатай.

Орон нутгийн төсөв зарцуулалт хэдэн хувь вэ гэдэг нь намар төсөв хуваарилалт дээр яригдана. Одоо салбарын зардлын хуваарийн асуудал яригдахгүй.

Н.Наранбаатар: Жавхлан гишүүн тодруулъя.

Б.Жавхлан: Уг нь Засгийн газраас өргөн барьсан зээлийн ашиглалтыг бид нар дэмжээд явж байгаа. Тэгэхдээ тэр дотор чинь бид нар ингэж амлаж байгаа шүү дээ. Зээлийн ашиглалтаа нэмнэ. Гэхдээ төсвийн хүрээнийхээ гадаад зээлийнхээ хязгаарыг бид нар хөндөхгүй. Энэ таазаа бол хөндөхгүй. Энийгээ бол нэвт цоолохгүй, энэ дотроо барина гэж хэлээд, ингэж амлаад, ингэж ойлгуулаад, тэгээд зээлийнхээ ашиглалтыг нэмж байгаа шүү дээ. Тэгэхээр одоо энэ чинь зээлийнхээ ашиглалтыг ч нэмнэ, өрнийхөө дээд хязгаарыг ч нэмнэ гээд. Тэгэхээр энэ мессеж чинь зөв үү, үгүй юу. Энийгээ нэг эргэж хараарай. Уг нь Энх-Амгалан тэр 2 зээлийн ашиглалтыг нэмээд, нэмээд уг нь 45 хувьдаа бол хангалттай багтахаар байгаа шүү дээ. Хангалттай багтаж байгаа шүү дээ. Энийгээ эргээд хараадхараарай.

Энэ ийм шүү дээ. 2027 оных чинь ингэх байхгүй юу. 2027 оны энэ алдагдал дотор чинь Энх-Амгалан 2026 оны орон нутгийн гараагүй зардал багтаж орно шүү

дээ. Тэгэхээр 2026 оны төсөв батлагдсан тэр орон нутгийн батлах төсөв биш байхгүй юу. Тэр чинь бүр 2028 он дээр очно. Энэ 2027 оны төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал дотор чинь би дахиад хэлье. 2026 оны орон нутгийн төсвийн энэ жил гараагүй зардал чинь тийшээ шингэж орно шүү дээ. Тэгэхээр тэрийг та нар тооцоолж оруулахгүй бол болохгүй шүү дээ. Одоо 2025 оны төсвийн гүйцэтгэл ярихад тэр яригдана. Өөрөөр хэлбэл 1,7 их наяд дээр чинь бараг 1,3 их наяд нь орон нутгийн төсвийн зардал байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл Засгийн газар нөгөө зардлаа шингээж чадахгүй, нөгөө алдагдал чинь орон нутгийн зардлаар дүүрчхээд байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд. 6 номер.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Тэр сүүлийн хэсэг дээр хариульъя. Алдагдлыг өмнө жил бид төсөөлөхдөө 2027 оны алдагдлыг ДНБ-ий 0,8 хувиар төсөөлж, батлуулсан байсан. Өмнөх төсвийн хүрээн дээр, төсөөллийн хэсэгт нь. Тэгээд энэ жил эдийн засгийн идэвхжил нэлээд буурч байгаа болохоор мөн хөрөнгө оруулалтын боломжууд нэлээн буурч байгаа болохоор ДНБ-ий 1,5 хувь руу болгож нэмэгдүүлж байгаа. Бараг 800 тэрбумаар нэмэгдүүлж байгаа. Тэгэхээр энэ нэмэгдүүлж байгаа орон зай нь агуулгаараа ч гэсэн бас тэр орон нутгаас энэ алдагдлын орон зайд нэлээд юм хуваарилах болов уу гээд Сангийн яамтай нийлж ярьж байгаад нэлээн нэмэгдүүлсэн ийм л тоо байгаа юм.

Зээлийн өр дээр бол Сангийн яамнаас яг нарийвчилсан тооцоон дээрээ хариулсан нь дээр байх.

Н.Наранбаатар: Сангийн яам. Ж.Ганбаатар гишүүнийг асуултад нэмчих. Сангийн яам 9 номер хариульъя.

Л.Гантогтох: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Жавхлан гишүүний асуултад хариульъя. Засгийн газрын өр дээр бол гадаад зээлийн ашиглалт яг ашигласан дүнгээр нэмэгдээд явдаг. Одоо Засгийн газраас өргөн барьчихсан байгаа гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх хуулиар бол яг одоогийн ашиглалт бол жилд 1,2 их наяд орчим гадаад зээлийн ашиглалттай байгаа. Хууль батлагдсанаар бол энэ ашиглалт бол жилд 3-4 их наяд болж нэмэгдэх ийм төлөвлөгөөтэй байгаа. Тэгэхээр одоо жил болгон ойрын жилүүдэд 3-4 их наядын гадаад зээлийн ашиглалт ингэж нэмэгдсэнээр бол бас Засгийн газрын өр дээр тодорхой хэмжээгээр нэмэгдэх ийм төсөөлөлтэй. Тэгэхээр 2027, 2028 онд бол хязгаарыг 50 хувь байхаар төсвийн хүрээний мэдэгдэл дээр оруулж ирсэн.

Н.Наранбаатар: Жавхлан гишүүн тодруульъя.

Б.Жавхлан: За байз, Эдийн засаг, хөгжлийн яамныхан Энх-Амгалан дарга аа, наад асуудлуудаа яг тэр нөгөө угаар нь сайн олж харж, сайдаа сайн цэнэглэж байгаарай. Наадах чинь ийм шүү дээ. Өмнө нь нөгөө гишүүдийн өргөн барьсан дотор наад орон нутгийн алдагдлыг чинь уг нь шийдчихсэн заалт байсан шүү дээ. Тэрийг Их Хурал дээр дэмжүүлж чадаагүй. Тэгээд сая Засгийн газар өргөн барихдаа тэр хэсгийг нь хасчихсан байна лээ. Одоо тэгэхээр ирэх жилийн 1,7 дотор чинь бараг 1,5 нь байна уу даа бараг орон нутгийн зардал ороод ирнэ. Тэгэхээр цаана нь Засгийн газарт маш бага орон зай үлдэж байгаа шүү. 1 дүгээрт. Тэгэхээр тэр хуулиа оролдох ёстой байхгүй юу. Орон нутгийн тухай хууль, Төсвийн тухай хууль тэр 57.3, 57.2 гэж байгаа, 64.1.2 гэж байгаа. Эдгээр заалтуудыгаа эргэж харж янзлах ёстой. Уг нь энийгээ дагуулж орж ирээд шийдчихсэн бол болох байсан. 1 дүгээрт.

2 дугаарт Гантогтох дарга аа, тэгэхээр наад тоонуудаа Эдийн засаг, хөгжлийн яаманд өгсөн л байлгүй дээ. 3-4 их наядаар нэмэгдэхээр нэмэгдсэн ч гэсэн 45 хувь дотроо барина шүү дээ. Чөлөөтэй барина. Наадах чинь 45 хувь гэдэг чинь одоо гүйцэтгэл чинь 38, 39 хувьтай гарсан байгаа. Цаана нь орон зайны чинь бараг 6 хувь байгаа байхгүй юу. 112 их наядын чинь 6 хувь гэдэг чинь бараг 7 их наяд байхгүй юу. Тэгээд наадах чинь 3-4 их наяд гэдэг чинь 45 дотроо хангалттай барина. Цаана нь дахиад л орон зай гарна. Тэгэхээр наадах чинь ингээд Засгийн газрын өрөө нэмэгдүүлэх гэж байгаа юм шиг ийм мессеж очих байхгүй юу хөрөнгө оруулагч нарт. 45 гээд хэдүүлээ ингээд 38, 39 дээр гүйцэтгэл нь авааччихаад 45-аас хэтрүүлэхгүй гээд дунд хугацаандаа баталчихсан шүү дээ. Цаашдаа энэ 4, 5 жил дор хаяж бид нар сахилга баттай ингээд явна гээд. Одоо наадхыг чинь гадна талдаа та нар дахиад бондод явна. Хамгийн түрүүнд энийг чинь асууна. Яагаад 50 болгочихсон юм бэ. Тэгэхээр хэрвээ ДНБ-ээ нэмэгдэж байгаа бол нэмэгдсэн хэрээр тэр 45 дотор чинь нэмэлт орон зай гарах учраас /минут дуусав/

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Өрийн тааз 60 хувь хуулиар хязгаар. Тэгээд Жавхлан гишүүний яриад байгаа 45 бол бодлогын хувьд их зөв. Эдийн засаг, хөгжлийн яамны бодлого бол энэ дээр байгаа. Ингээд 5 хувиар нэмэгдүүлж байгаа нь бид нар Засгийн газарт хөрөнгө оруулалтын шинэ шинэ саналууд, гадаад зээлийн асуудлууд гарч ирж байна. Жишээлбэл, нисэх буудлыг өргөтгөх. Манай 8 гарцтай Чингис хаан нисэх хаан онгоцны буудал ачаалал нь 3 дахин хэтэрсэн. 2,4 сая зорчигч авчихсан. Одоо ингээд Японы Засгийн газартай дараагийн 11 гарц бүхий дараагийн шинэ нисэх буудлын асуудал, дэд бүтцийн асуудлууд, замын хөрөнгө оруулалтууд, гадаад зээлийн ашиглалтууд яригдаж эхэлж байна. Тэгэхээр тэндээ ямар ч байсан 5 хувийн нөөцтэй явъя. Шинэ эдийн засгийг идэвхжүүлэх яг энэ төсөв санхүүгийн хүнд үед гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн ашиглалтыг нэмж явах нь их зүйтэй гэдэг ийм зүйл дээр бид санал нийлсэн. Тэгээд оруулж ирсэн байгаа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Энэ дунд хугацаандаа төсвийн чинь зардал бараг 40 их наяд төгрөг болох юм байна. Тэгээд Эдийн засгийн яамны бодлоготой чинь нийцэж байгаа юу. Таны хариулж байгаа хариултуудыг өмнөх Байнгын хороод дээр тийм ярьж байгаа зүйлтэй чинь энэ чинь нийцэхгүй юм. Тэгээд дунд хугацаандаа 40 их наядын зардалтай. Тэгээд багасгана, багасгана гээд зөндөө ярьсан. Энэ нүүрсний үнийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг уншихад тэр 127 доллар, тэгээд чадах юм уу. Тэгээд өнөөдөр яг бодитой дундаж үнэ нь хэд байгаа юм. Тэр 127 доллар гэдгийг би өөрөө хэлээгүй шүү. Тэгээд энийг чадах уу.

Дараа нь 1 зүйл асууя. Энэ өнөөдрийн яг төсвийн алдагдал та болохоор ингээд түүхэнд байхгүй нүүрс гаргасан. Түүхэнд байхгүй зэс өндөр үнэтэй байна. Бараг бүх л юм түүхэнд байхгүй их экспортлогдоод байна. Тэгээд төсвийн алдагдал ингээд өсөөд байна. Цаашаа төсвийн алдагдал өсөх юм уу, буух юм уу. Тэгээд энэ төсвийн алдагдал чинь ер нь яагаад гарсан юм. Яасан юм. Энэ хүмүүс ингээд энд тэнд хариулаад байгааг нь сонсохоор урьдчилаад аваад хэрэглэчихсэн юм. Одоо янз янзын юм яриад байна лээ л дээ. Яг таны амнаас сонсьё. Төсвийн алдагдлын гол суурь шалтгаан нь юу байгаа юм. Түүхэнд байхгүй их экспорт хийгээд байгаа мөртөө төсөв маш том алдагдалтай. Өөр өөр хариултуудыг сонсож байгаа. Тийм учраас Эдийн засгийн байнгын хороон дээр сонсьё.

Тэгээд энэ хэрэглээний үнийн индекс. Би жил болгон ярьдаг юм л даа. Худлаа аргачлалтай, худлаа тоо гээд. Тэгээд хариулж байгаа хүмүүс нь хэрэглээний тэр сагсны бараа гээд одоо энэ сагсны бараа чинь бүр тоймгүй үнэтэй болчихсон биз дээ. Мах, сүү, гурил, будаа. Тэгээд энэ хэрэглээний үнийн индексээ хардаа. Өсөлтийн түвшин тэгж нэрлэдэг болсон юм байна. Тэр 7 хувьтай, 6 хувьтай, 5 хувьтай. Тэгээд ноднин, уржнан ер нь бүх л цаг үед л бодитой болгооч, аргачлалаа өөрчлөөч. Тэгээд худлаа тоо яриулаад, худлаа юм яриад байх юм. Тэгээд хариултаа аваад, тодруулъя.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Нүүрс 127 гэдэг бол нөгөө тэнцвэржүүлсэн үнэ. Хуулиар тусгайлаад заагаад өгчихсөн. Сүүлийн 20 жилийн үнийн дунджийг барь л гэж байгаа юм. Манай нүүрс чинь нөгөө 300 доллар давж байсан үеийг нь их өндөр түвшинд татаад, доошоо буухдаа бид нар 20, 30 доллар хүрч байсан. Энэ 2-ын хооронд л нүүрсний салбарын савалт явчихсан. Тэгээд дундаж гарахаар 127 байгаа. Одоогийн үнэ бол яг энэ зах зээлийн эрэлтдээ нийцээд, ашигт ажиллагаагаа хангаад явж байна. Экспорт сайн байна. Ноднингийн мөн үеэс 2,2 тэрбум долларын илүү экспорт үнийн дүнгээр ч тэр, биет хэмжээгээр ч тэр хийчхээд байна.

Тэгэхээр төсвийн алдагдлын гол учир шалтгаан бид нарт урсгал зардлаа л нэмчихсэн асуудал байна л даа. Цалин, тэтгэврийн нэмэгдлийг огцом хийчихлээ. Тэгээд одоо бид нар 2027 оны тухай л ярьж байна. 4 их наяд төгрөгийн тооцоолоогүй шинэ зардал нэмэгдчихээд байдаг. Гэтэл нөгөө эдийн засгийн суурь чадавх маань өсөөд, экспортоо нэмэгдүүлээд, үйлдвэрлэлээ нэмэгдүүлээд яваад байгаа чадавх маань жилийн өсөлт нь 6 хувь, 5 хувь гээд эдийн засгийн өсөлтөө тооцож байгаа хэмжээгээ л бариад л байна. Төлөлтөө бариад яваад байна. Тэгэхээр урсгал зардлын эрс өсөлт энэ нөхцөл байдал руу хүргэж байна гэсэн үг.

Нөгөө талаас хэрэглээний үнэ инфляц тооцогддог аргачлал бас л хуулиар заасан сагсны 430 барааны хүрээнд гарч байгаа. Үүн дотроо хүнсний барааны бүлэг үнийн өсөлт өндөр. 1 онцлог байгаа юм. Дотоодоосоо зохицуулж болох боломжтой мах, ногоо, гурил, будаа, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлт өндөр гараад байгаа юм. Инфляцын 10,5 хувийн өсөлтийн бараг 3,7 хувь нь дангаараа махны өсөлт гарчхаж байгаа юм. Тэгэхээр бид нар мах бэлтгэл, зохион байгуулалтын алдаа гарсан нь тодорхой байгаа. Нийлүүлэлт дээр жоохон алдаа гарсан нь тодорхой байгаа. Энийгээ Хүнсний тухай хуулиар уг нь орон нутаг, аймаг, нийслэл зохион байгуулаад, төсөвтөө суулгаад хийгээд явж ирсэн. Өнгөрсөн хугацаанд сүүлийн 3 жил ийм айхтар өсөлт, ийм зохицуулалтын алдаа гараагүй л явж байсан ажил байхгүй юу даа. Тэгээд энд Засгийн газар өөрийн эрхгүй оролцоод, зохион байгуулалттай арга хэмжээг авч, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, Засгийн газар хянан шалгах эрхээ хэрэгжүүлэх ийм ажлууд л хийгдэж байна. Тэгэхээр эдийн засгийн суурь өсөлт маань тасралтгүй зорилтынхоо түвшинд 5-8 хувь дотор л Монгол Улсын эдийн засаг тасралтгүй өсөөд л байна. Бид урсгал зардал гэдэг дээрээ л жоохон анхаарч өгөөч ээ л гээд байгаа юм. Урсгал зардлын огцом нэмэлт маань өөрөө нөгөө эдийн засгаа дэмжих, хөрөнгө оруулалт хийх, том хөгжлийн төсөл хөтөлбөр хийх тэр боломжоо хязгаарлаад л ийм байдал руу орж ирж байгаа байдал нь 2027 онд бол их өндөр түвшинд гарч ирээд байгаа юм. Тэгэхээр энд л асуудал үүсэж байна.

Тэгээд ер нь нүүрсний одоогийн зах .../минут дуусав/

Н.Наранбаатар: Тодруулах уу. Гүйцээж хариулъя. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Гишүүд ээ, энэ нүүрсний одоогийн зах зээлийн үнэ 2027 оны бодлого эд нараа яриад хэрэггүй байх гэж бодож байна. Ер нь нүүрсний зах зээл идэвхтэй байна. Боломжийн байна. Манайх энэ үнийн болон нийлүүлэлтийн бодлогоо нэлээн дотроо хар хайрцгийн бодлого авч явах ёстой. Тэрнээс өнөөдөр эдээр өгнө, тэдээр өгнө гэж ил зарлаад, тэрийгээ төсөвлөөд хэрэггүй байх. Яг зах зээлийнхээ 20 жилийнхээ юмаа харж байна. Ирэх 3 жилийн дэлхийн үнэлгээний, судалгааны байгууллагууд ерөнхий тэндээс гарч байна. Манай таамаглал дээр ойролцоо байна. Тэгэхээр ирэх 3 жил нүүрсний салбар эвтэйхэн байна. Биет хэмжээг нэг их айхтар нэмэхгүй байр суурь байна.

Нөгөө талдаа зах зээл чинь бас ёроолгүй зүйл биш. Тодорхой хэмжээнд бид нар бариад, тодорхой хэмжээнд аль болох үнэтэй, баяжуулсан нэмүү өртөг шингээсэн экспортоо л илүү анхаараад явъя л гэсэн ийм маягаар.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Тэгээд асуулт маш аятайхан зөөлөн асууж байгаа шүү. Тэгээд хариулахдаа наад нэг тийм заасан юмаа жоохон багасгаарай. Та ер нь тийм яг Эдийн засгийн сайд шиг биш, Батлан хамгаалахын сайд шиг хариулсаар байгаад сурчихсан. Наадхаа жоохон багасгаж, наад эдийн засгийн байдалтай ярьж сурахгүй бол геополитик ярьдаг хүний амаар л ерөөсөө. Тэгэхээр наадхыгаа би маш юу асуусан шүү. Тэгээд яах вэ, тэр нүүрсний үнийг ойлголоо. Би өөрөө сайд байсан хүний хувьд бол ойлгож байна. Тэрийг нь тойрьё.

Наад хэрэглээний үнийн индекс чинь зөв гаргамаар байна шүү дээ. Энэ аргачлалаа зөв болгомоор байна. Эдийн засаг, хөгжлийн яам л мэднэ шүү дээ Энхбаяр сайд аа. Тэгээд дандаа худлаа тоо ярина. Тэгээд тэр тоогоо ярихаар дандаа тойроод өөр хариулна. Яг таны ярианаас авчихаар хариулт байхгүй байна шүү дээ. Тэгэхээр хэрэглээний үнийн индексээ зөв болгох хэрэгтэй. Би дуусаагүй байна. 58 секунд дутуу байх шиг байна.

Тэгээд төсвийн алдагдал чинь яг яачихсан гэлээ. Яг яагаад төсвийн алдагдал чинь ийм их байгаа юм бэ. Та одоо яг тодорхой хэлээч. Яасан юм, яг юунаас шалтгаалсан юм. Өмнөх сайд нараасаа шалтгаалсан юм уу. Өмнөх Засгийн газрын буруу бодлогоос шалтгаалсан юм уу. Тэгээд би энэ Байнгын хорооны даргыг хариулж байгааг бас сонссон юм. Коридорт сэтгүүлч нарын асуултад хариулж байгааг. Таны бас энд тэнд хариулж байсан хариултаудыг сонссон. Тэгээд төсвийн алдагдал чинь цаашаа үргэлжлээд нэмэгдэх юм уу, эсвэл буух юм уу. Та наад экспортоороо наадхаа нөхөөд явчхаж чадах юм уу. Ингээд минут дуусчихлаа л даа.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 1,5 хувь алдагдалтай төлөвлөж байгаа. Алдагдал гэдэг маань өөрөө муу зүйл биш шүү дээ. Эдийн засгаа дэмжсэн, мөчлөг сөрсөн л бодлогын хүрээнд бид алдагдлаа нэмж, тэр алдагдлын хэмжээгээр гадаад зээлийн ашиглалтаа сайжруулж байгаа зүйл. Эдийн засаг, төсөв ашигтай, орлого сайтай, эдийн засаг идэвхтэй үед бол төсвийг алдагдалгүй батлаад, хуримтлал үүсгээд, эдийн засаг халахаас сэргийлээд ингээд явдаг. Одоо бол ялангуяа эдийн засгийн гол суурь болсон худалдаа үйлчилгээний салбарт 40 гаруй хувийг эзэлж байгаа салбарт бодлогын дэмжлэг хэрэгтэй. Энэ бодлогын дэмжлэг маань алдагдал буюу

гадаад зээлийн ашиглалт, төсвийн алдагдал 2-оороо дамжиж нөлөөлнө гэж ингэж тооцож байгаа зүйл. Нөгөө инфляцтай холбоотой энэ бүх юуг бол хөндлөнгийн Үндэсний статистикийн хороо бүх судалгаа, дүн шинжилгээгээ хийгээд, холбогдох хуулийнхаа хүрээнд ингээд мэдээллээ гаргаж байгаа шүү дээ. Дэлхий ертөнц нийтээрээ учирч байгаа зүйл бол инфляцын өсөлт. Манайх шиг хөгжиж байгаа орнуудад бол нэмээд төсвийн дарамт ийм 2 л асуудал орж ирж байна. Үнэхээр суурь зардал болсон шатахууны үнийн өсөлт бол гол бараа дээр нэлээн хүчтэй нөлөөлж байна. Засгийн газар бодлогын арга хэмжээ, хариу арга хэмжээнүүдийг тасралтгүй авч байна. Үнийг 1 дүгээрт шатахуун тасралтгүй байх нь, хүрэлцээтэй байх нь тэргүүний ээлжид энийгээ хангаж байна. 2 дугаарт үнийг өсгөхгүй байх, үнийн зохицуулалтыг холбогдох яамд хөрш орнуудтайгаа амжилттай хийж байна. Харьцангуй шатахуунтай холбоотой өсөлт бусад оронтой харьцуулах манайд боломжийн түвшинд, тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа. Харьцангуй энийгээ бид нар удирдаад хянаад явж байна. Дунд хугацаанд 7, 8 сард хэрвээ Ойрх Дорнодын нөхцөл байдал яахаас ч цаашдаа өрнөл үнэхээр шалтгаална. Манай хамгийн сул тал нь энэ хамаарал. Иймд л энэ гадаад зээлийн ашиглалтын .../минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмээд хариулчих.

Ж.Энхбаяр: Ийм болохоор гадаад ашиглалтын хуулийг санаачлаад, гадаад ашиглалтаа нэмээд, Алтанширээгийн нефть боловсруулах үйлдвэрийг хурдан барих асуудлыг л түргэвчилье гэдэг ийм хуулиуд орж ирээд байгаа учир нь тэр. Тэгэхээр гол шалтгаан бол 1 дүгээрт шатахуунтай холбоотой зүйл байна.

2 дугаарт дотоод үйл ажиллагаатай зохицуулалтын алдаатай холбоотой ялангуяа энэ махан дээр гарч байгаа асуудал. Гурил, гурилан бүтээгдэхүүнтэй холбоотой асуудал мөн адилхан шүү. Төмс хүнсний ногоо гээд. Тэгэхээр энэ чиглэл дээр дотоодоосоо нийлүүлж байгаа, дотоодоос хамааралтай инфляцын өсөлтийг бид бодлогын хувьд зохицуулалт хийгээд ийм арга хэмжээг авч байна. Тариалалтыг хямд хийхийн тулд шатахуун түлшээр хангаж байна. Үр бордоогоор хангаж байна. Зохион байгуулалтын хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгүүдийн ажлуудыг хийж байна. Энэ намрын ургацаар төмс, хүнсний ногоо, үр тариа, гурилан бүтээгдэхүүн, тэгээд мал махны нийлүүлэлт сайжраад инфляц дунд хугацаандаа ойрын үед буугаад нийлүүлэлт сайжраад явчихна гэсэн хүлээлттэй байгаа. Энэ инфляцын гол шалтгаан бол .../минут дуусав/

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Таны хариултыг сонсохоор ер нь бол надаас шалтгаалаагүй. Их Хурал зардал нэмээд байна. Хэрэглээний үнэ индекс би хамаагүй. Ийм юм байхгүй шүү дээ. Үгүй ээ, энэ чинь та өөрөө энэ хуулиа өөрөө өргөн барьж байгаа биз дээ. Энэ тоо баримтуудаа өөрөө нэгтгээд, өөрөө үнэн зөв болгоод, тэгээд өргөн барих ёстой шүү дээ. Эдийн засгийн байнгын хороон дарга ч гэсэн энэ тоонуудыг чинь нэгтгээд, хэрвээ худлаа бол Байнгын хороогоор оруулахгүй байх ёстой шүү дээ. Тийм эрхтэй. Би хэрэглээний үнийн индекс ярьж байна. Та болохоор тэр юу руу яриад байна шүү дээ. Статистикийн ерөнхий газар мэдэж байгаа. Би мэдэхгүй гээд байна шүү дээ. Та хариултаа өөрөө ойлгож байгаа юм байгаа биз дээ. Юу яриад байгаа юм гэж, харин та юу яриад байгаа юм. Тэгээд энэ зардал нэмэгдэхгүй байх, урсгал зардал нэмэгдэхгүй байх талаар та өөрөө санаачилгатай байх ёстой шүү дээ. Хэн нэмээд байгаа юм наад зардлыг чинь. Тэгээд дунд хугацаандаа 40 их наяд болчихлоо гэхлээр нэмэхгүй гээд байгаа юм уу, нэмье гээд байгаа юм уу. Яг хэнээс шалтгаалаад байгаа юм. Тэгэхээр би бол тэгээд 1 хөндлөнгийн хүнээс шалтгаалаад

байгаа юм шиг, эсвэл Их Хуралд зүгээр тийм дундын байр сууриас биш. Энэ хариултууд чинь буруу байна. Би санал хэллээ. Хариулт шаардлагагүй. Баярлалаа.

Н.Наранбаатар: Гантөмөр гишүүн асуулт асуу. Асуулт биш. Сая санал хэлсэн.

Л.Гантөмөр: Үнэхээр буруу байна. Одоо ингээд улам буруу явъя гэдэг ийм хандлага тогтоод байна Наранбаатар дарга аа. 2025 оны төсөв баталж байсан Их Хурал хаачсан бэ. 2025 оны төсвийг алдагдалгүй баталж байхад би Эдийн засгийн сайд алдагдалтай оруулж ирээд, алдагдалгүй төсөв батлуулаад гарахдаа аймар их баярлаж байсан юм. Яагаад баярлаж байсан бэ гэхээр үнэхээр энэ парламент бол Монголыг зөв тийш нь эргүүлэх хүч болох бололцоотой юм байна гээд.

Гэтэл өнөөдрийн энэ хуралдаж байгаа байдал, санал өгч байгаа байдлыг харахаар ямар аймар сул дорой болж байна. Саяын Ганбаатар гишүүний асуултад хэн ч хариулж чадахгүй байна. Өнгөрсөн жилийн төсөв дээр Жавхлан тун аятайхан байж байгаад, сүүл рүүгээ аймар хүчиндүүлсэн. Тэрийг хүчиндүүлэх процесст бол Төсвийн байнгын хороо тэр чигтээ автчихсан. Тэгээд одоо төсвийн хүрээний мэдэгдэл дээрээ дахиад хүчиндүүлж байгаа юм. Ингээд байхаар энэ парламентын ардчилал гэдэг зүйл чинь юу болох юм бэ.

Би Энхбаяр сайдаас асуумаар байгаа юм. 7 хоногийн өмнө Их Хурал унагасан хуулийг та нар оруулж ирж байгаа чинь юу юм. Яаж байгаа юм. Монголын парламентыг доромжилж байна шүү дээ. Үгүй ээ, тэр Алтанширээ гэдэг үйлдвэрийн ажлыг хийж байгаа Энэтхэг компанийнхаа нэрийг мэдэж байгаа юу. Юу гэдэг компани юм. Захирал нь хэн юм. Тэр төлбөрийн хэлэлцээрийг Энхбаяр чи хийсэн үү. Одоо энэ НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлж байгаа гээд Зандан болоод бусад нь бүтэн жил популизм хийсэн. Одоо тэр хуулийг хүчингүй болгоно гэж байгаа юм. Үгүй ээ, юу болж байгаа юм бэ. Монгол Улс дарангуйлалд орж байгаа. Тэрийг бүгд мэдэж байгаа, харж байгаа. Тэгэхдээ Монголын парламент 1 жилийн дотор ийм сул дорой болж болохгүй ээ нөхөд өө, Наранбаатар дарга аа, одоо Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын 170 сая долларыг 2 жилийн дотор гаргаж өгье гэж байгаа юм. Ямар компани барьж байгаа юм. Хэдэн жилийн төлөвлөгөөтэй юм. Мөнгөгүй компани юм уу. Үгүй ээ, энэ чинь хэн ч гэсэн хэлэлцээр хийдэг биз дээ. Мөнгөө гаргаад, ажлаа хийгээд, мөнгө нь бэлэн байна. 5 жилийн хугацаанд .../минут дуусав/

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Монгол Улсын хамгийн гол анхаарах ёстой юм бол эрчим хүчний салбар. Эрдэнэбүрэнгийн УЦС олон жил улс төржсөн. Баруун 5 аймагт импортоор ОХУ, БНХАУ-аас эрчим хүч авч, хэрэглээгээ хангаж байгаа. Энэ төслийг яаралтай оруулах нь улс орны эрх ашигт л нийцтэй байгаа. Энэтхэгийн зээл. Алтанширээ нефть боловсруулах үйлдвэр 1 сая 500 мянган тонн түүхий нефть боловсруулах. Энэтхэгийн Засгийн газар нэн хөнгөлөлттэй зээлээ өгөөд, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаад, хурдан бариад ашиглалтад оруулъя гэхэд бид манай хязгаар ийм байна. Бид энийг хурдан хийж чадахгүй гэж байгаа л байдалтай байгаа шүү дээ. Тэгэхээр энийг хуулийн гадуур гаргаж хурдан хийе л гэж байгаа. Санал гаргасан гишүүд маань нэмээд Улаанбаатар хотын Сэлбэ төвийн асуудлыг оруулсан байна. Гишүүд энэ дээр шүүмжлэлтэй хандсан. Иймд Засгийн газар өөрийн хувилбар буюу эрчим хүчнийхээ 2 том төслийг аваад гаръя. Нийслэл хотод хэрэгжиж байгаа төслийг орхиод хасаад, дахин өргөн барьж байгаа асуудал. Энэ бол улс орноо бодож байгаа л асуудал.

2.НӨАТ-ын асуудал. НӨАТ-ын буцаан олголт 20 хувь олгож байгаа. Одоо үйлчлэх гэж байгаа хууль бол 50 хувиар буцаая гэдэг хууль. Бодит байдал маань хүсэл хясал 2 маань зөрөөд байна л даа. Багш, эмч, урсгал зардал, тэтгэвэр инфляцад холбоотой нэмэгдлүүд өндөр гарч ирээд байна. 2027 онд 4 их наядын ачаалал үүсээд байна. Тэрийг нөхөх хэмжээний үйлдвэрлэл орж ирэхгүй. Орлого ороогүй байна. Иймд нэмж зардал үүсэх, урсгал зардлыг нэмэгдүүлэх. Энэ чинь бараг 1.0 хэдэн их наядаар нэмж байгаа билээ. НӨАТ чинь. 1,8 их наядаар ахиж улсын төсвийн орлого буурах ийм хуулийн төслийн хэрэгжилтийг хойшлуулах нь зүйтэй л гэдэг л санал шүү дээ.

Гэхдээ энэ Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Үгүй ээ, НӨАТ-аа буцаана, хөрөнгө оруулалтаа зогсооно гэвэл 1,8 их наядын чинь эсрэг талд 2,2 их наядын л хөрөнгө оруулалтын орон зай үүсэж байгаа. Засгийн газрын орон зай нь энэ. Шинэ хөрөнгө оруулалт байхгүй. Одоо гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалттай 3,6 их наядын хөрөнгө оруулалт байна. Үүнээсээ 2,2-ыг л санхүүжүүлэх эдийн засгийн боломж байна. Хэрвээ энэ хууль үйлчлээд эхлэх юм бол таны ярьснаар одоо ажиллаж байгаа, шилжиж байгаа хөрөнгө оруулалтууд бүрэн зогсоно гэсэн үг. Тэгэхээр тооцоо, эрсдэл, нөлөөллийг нь гаргаад өглөө. Энэ дээр шийдэл нь Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Бид бол бүх байдлыг нь эрсдэлтэй нь нөлөөлөлтэй нь тооцоотой гаргаад өгч байгаа юм.

2 дугаарт төсөв алдагдалгүй гаргана гэдэг эдийн засгийн тухайн цаг үеэсээ шалтгаалдаг энэ чинь бодлогын л хэрэгсэл шүү дээ. Эдийн засаг төсвийг алдагдалгүй гаргахаар ямар үед алдагдалгүй гаргадаг билээ. Алдагдалтай/минут дуусав/

Н.Наранбаатар: Гантөмөр гишүүн тодруулъя.

Л.Гантөмөр: Тэгэхдээ Энхбаяр аа, чи асуусан асуултад хариул л даа. Энэтхэгийн ямар компани тэр газрын тосны үйлдвэрийг чинь барьж байгаа юм бэ. Чи болоод Эдийн засгийн яам уулзсан уулзалт байна уу. Тэр улсууд чинь мөнгө төгрөгөө гаргаад, юмаа яагаад барьдаггүй, заавал энэ улсаас мөнгө авч байж ажил хийнэ гээд суугаад байдаг юм бэ. Тэгэхээр чи тэр Сангийн яамнаас асуугаад байгаа биз. Надад олдоогүй байхгүй юу Энхбаяр аа. Чи тэр үгээ хэлэх хэрэгтэй шүү дээ. Тэр компани надад олддоггүй юм гээд. Эрдэнэбүрэн адилхан. Ямар ч асуудалгүй тэр компани бол барьдгаа барьчихна. Өмнөөс нь мөнгийг нь маш яаралтай өгье гээд гүйгээд байгаа хэн байгаа юм бэ. Тэр танилцуулгаа бидэнд өг л дөө. Уулзалтынхаа протоколыг өг л дөө. Хийсэн төлөвлөгөөгөө өг л дөө. Хэдэн удаа уулзсан юм. Ямар машин хаанаас худалдаж авч байгаа юм. Тэрний гэрээ хэлэлцээр нь юу байгаа юм. Тэгээд л оруулж ирээд л хүчиндээд байх юм. Тоглоомгүй. Төсвийг алдагдалтай баталдаг юм л гэдэг баталж болно. Зүгээр л өр нэмж байгаа шүү дээ. 2028 оны засгийг л ажилгүй болгож байгаа. 2029 оны засгийг ажилгүй болгож байгаа. Ирээдүйд энэ ард түмнийг өрөнд оруулж байгаа юм. Үнэн шүү дээ. Урсгал зардлыг бууруулах аргагүй байна л гээд байгаа юм. Ямар ч асуудалгүй бууруулж болно шүү дээ. Жавхлан сайд бол баахан алдагдлыг 24 хувьд нь багтаагаад барина гээд л сүрхий хамгаалаад явсан шүү дээ. Та нар буцаад л 28 болгочихсон. Биш 31 болгочихсон. Үгүй ээ, тэгэх ямар хэрэгтэй юм. Зүгээр олж байгаа мөнгөнийхөө хэрээр л амьдар л даа.

Эдийн засаг гэдэг чинь шал өөр газар байгаа шүү дээ. Тэр хөрөнгө оруулагчид гэдэг чинь шал өөр газар байгаа шүү дээ Энхбаяр аа. Чи болохоор зүгээр л төсвийн орж байгаа хэдэн .../минут дуусав/

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: Энэ гадаад зээлийн ашиглалтын талаар Сангийн яамны яг хариуцсан газрын дарга хариулна. 9 номер.

Н.Наранбаатар: 9 номер.

Ж.Дэлгэржаргал: Гантөмөр гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Тэгэхээр газрын тосны боловсруулах үйлдвэрийн гүйцэтгэгч бол БНЭУ-ын Мега Инженеринг гэдэг компани байгаа. Эрдэнэбүрэнгийнх бол Повер Чайна буюу Хятадын төрийн өмчит компани байгаа. Тэр зээлийн ашиглалтын хууль бол яг одоо энэ зээлийн хэлэлцээрүүдийн хугацаанд газрын тос бол хамгийн тулгамдчихсан байгаа. Одоо 2028 онд Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Зээлийн хэлэлцээр дуусах ёстой. Үлдэгдэл буюу зээлийн ашиглалтаас ашиглагдаагүй байгаа үлдэгдэл 4,7 их наяд байгаа. Энэ тооцооллоор харах юм бол бид нар жилд төсөв дээр зөвхөн газрын тос боловсруулах үйлдвэр дээр 1,5-2 их наядыг тусгах шаардлагатай. Гэтэл одоо яг Улсын Их Хурлаар соёрхон баталсан нийт зээлийн төслүүдийн хэмжээнд 1,2 их наядыг л Улсын Их Хурал буюу төсвийн хязгаар дотроо урсгал зардал, төсвийн хөрөнгө оруулалт шиг тэр зардал дотроо оруулж тооцоод, 1,2 их наяд батлагдаж байгаа. Тэгэхээр энэ тооцооллоор орох юм бол яг 2028 онд бид нар бол газрын тосны үйлдвэрийг яг ашиглалтыг нь нэмэгдүүлж гаргах боломжгүй байгаа. Гадаад зээлүүдийн хувьд бол тухайн Энэтхэгийн Эксим болон Хятадын Эксим банк талдаа бол Монгол Улсын Засгийн газарт яг 2028 он, 2030 он гэхэд бид нар энэ хэмжээний зээлийн ашиглалтыг ашиглана гээд амлалт үүсчихсэн. Ашиглалт болохлоор яаж явдаг вэ гэхээр гүйцэтгэл нь яг ирээд, бид нар Эксим банк руу яг Сангийн яамнаас албан ёсоор гүйцэтгэлийг баталгаажуулаад, захиа явсны дараа санхүүжилт нь орж ирдэг. Эксим банкнаасаа гүйцэтгэгч рүү шилжүүлдэг гэсэн үг. Яг энэ ашигласан дүнгээрээ бас өрнийхөө тооцоололд ашигласан дүнгээрээ тооцож явж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл яг энэ бид нар гүйцэтгэлийнх нь дагуу санхүүжүүлэх болохоос биш энэ хууль батлагдсанаар гүйцэтгэл гараагүй байхад нь бид нар санхүүжилтийг олгох боломжгүй.

Нөгөө талдаа болохоор яг энэ хэлэлцээрийн дүн буюу Улсын Их Хурал яг энэ хэлэлцээрийг хэдэд одоо .../минут дуусав/

Н.Наранбаатар: Гантөмөр гишүүн асуулт асууя. Тодруулж.

Л.Гантөмөр: Би түрүүн нөгөө Ганбаатар гишүүний ярьсан хариуцлагын тухай л асуугаад байгаа юм л даа Дэлгэржаргал аа. Тэгээд ингээд тулчихсан. 2028 онд хэлэлцээр дуусах гэж байхад одоо хүртэл хийгээгүй хариуцлагыг хэн хүлээх юм. Хэн хэдэн удаа тэр Энэтхэг компанитай ярианд орсон бэ. Ийм асуулт байгаа байхгүй юу.

Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын санхүүжилтийг бол бид нар 2025 онд шийдсэн. Тийм ээ. Энэ Повер Чайнатай хэн хэлэлцээрт орж байгаа юм бэ. Бид нар бас мэдмээр байна шүү дээ. Тэгээд төлөвлөгөө нь юу юм бэ. Хэдэн жилийн төлөвлөгөөтэй байгаа юм бэ. Жилд хэдэн доллар төлөх юм бэ. Та нарын төлөвлөгөөгөөр. Дээгий чи ер нь өөрөө тэр Энэтхэгийн компанитай уулзалт хийж үзсэн юм уу. Чи одоо 3 жил хамгаалж явж байгаа шүү дээ. Тэд нартай ер нь хэлэлцээр хийдэг юм уу. Тэгээд одоо орж ирэх төлбөрийн нэхэмжлэлүүд чинь яг юун дээр орж ирэх юм. Юу худалдаж авахад энэ төлбөрүүд чинь гарах юм. Энэ

төлөвлөгөөг хэн мэдэж байгаа юм. Тэгээд хар хүний өмнөөс шар хүн гэгчээр та нарын өмнөөс Эдийн засгийн сайд чинь энд ингээд л худлаа яриад л яваад байдаг. Одоо мөнгө шийдэгдэнгүүт л тэнд пүл пал гээд л үйлдвэр босчихно гээд ингээд худлаа хүлээлт үүснэ шүү дээ. Ачаа нь хаана явж байгаа юм. Хэнээс худалдаж авсан юм. Ийм тодорхой зүйл рүү орохгүй бол бид нар сахилга хариуцлага гэдэг зүйлгүй болохоор л төсөв чинь ийм үрэлгэн байгаад байгаа байхгүй юу. Ийм болохоор Энхбаяр сайд аа, та энэ хүмүүстэйгээ хариуцлага тооцож сурахгүй бол энэ алдагдал чинь улам нэмэгддэг л байхгүй юу даа. Та бол цэвэр сахилга хариуцлага, яг төсвийн урсгал ../минут дуусав/

Ж.Энхбаяр: Одоо бид бол төсвийн хүрээ макро эдийн засгийнхаа 9 тоогоо л ярьж байгаа шүү дээ. Тэгээд Гантөмөр гишүүн ээ, энэ гүйцэтгэж байгаа төсөл тендерийн хэрхэн хэрэгжиж байгаа, хэн хэрэгжүүлж байгаа, ачаа тээвэр хаана яваа гээд энэ асуудлыг энд ярих нь зохистой зүйл биш гэж бодож байна. Гадаад зээлийн ашиглалтын тухай хуулийг өргөн барьчихсан. Одоо хэлэлцэж байгаа. Тэр хүрээнд бүгдээрээ сайн задалж ярья. Бид нар гадаад зээлийн ашиглалт бүрээр бид нар эрэмбэлж байгаа, бүх түвшинд. Тэгье ээ, тэгье. Одоо энэ бүх гадаад зээл, ашиглалт гэрээ чинь Сангийн яаман дээр хийгдээд л явдаг шүү дээ. Эдийн засгийн яам бол гол бодлогын хүрээнд нь төсөл эрэмбийн ач холбогдлоор нь эрэмбэлээд л энэ эдийн засагт хэрэгтэй гэдгээрээ л явж байна шүү дээ. Тэгээд Таны мэдээлэл би тодруулаад, ийм юм явж байгаа юм байна, төслийн явц ийм байгаа юм байна гээд газар дээр нь очоод үзсэн ч болно. Бүтээн байгуулалт сайн өрнөж байгаа.

Н.Наранбаатар: Гантөмөр гишүүнд мэдээлэл өгөөрэй. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураана. Улсын Их Хурлын гишүүн. Байхгүй. Дэгээрээ үг байхгүй.

Дэгийн тухай хуулийн 39.14-д зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд 2 хоногийн өмнө бичгээр урьдчилж өгөх ёстой юм байна. Тийм учраас би ирсэн зарчмын зөрүүтэй саналуудыг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байна.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх

- нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2027 онд “36,493.4 тэрбум төгрөг” гэснийг “34,318.8 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “31.9” гэснийг “30.0” гэж, 2028 онд “38,644.0 тэрбум төгрөг” гэснийг “36,355.9 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “30.4” гэснийг “28.6” гэж, 2029 онд “40,444.7 тэрбум төгрөг” гэснийг “39,596.2 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “28.6” гэснийг “28.0” гэж;

-нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2027 онд “32,495.4 тэрбум төгрөг” гэснийг “26,316.7 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “28.4” гэснийг “23.0” гэж, 2028 онд “34,827.4 тэрбум төгрөг” гэснийг “27,963.6 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “27.4” гэснийг “22.0” гэж, 2029 онд “36,908.5 тэрбум төгрөг” гэснийг “31,110.6 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “26.1” гэснийг “22.0” гэж;

- ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/ 2027 онд “5.8” гэснийг “6.3” гэж, 2028 онд “6.0” гэснийг “6.5” гэж, 2029 онд “6.3” гэснийг “6.0” гэж;

- Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин 2027 онд “7.0” гэснийг “6.5” гэж;

- Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 2027 онд “57,114.9” гэснийг “51,403.4” гэж, 2028 онд “63,610.1” гэснийг “57,249.1” гэж тус тус өөрчлөх, эдгээр өөрчлөлтүүдтэй уялдуулан эдийн засгийн бусад үзүүлэлтэд нөлөөлөх нөлөөллийн тооцооллыг хийх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Үг байхгүй юм байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 2 хүн дэмжиж, 6,5 хувиар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Танилцуулах хүн байна уу. Энхтүвшин гишүүн танилцуулна. Дэг байхгүй.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

12.12 цаг.

2 дахь асуудал.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Хэвээрээ биз дээ. Ажлын хэсэг хэвээрээ учраас дахиж унших шаардлагагүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэлье.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Түвшин гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүн асуулт асууя.

Г.Уянгахишиг: Энэ нөгөө Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах гээд одоо уг нь энэ 2026 оны 10 сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчлэх, 2027 оны 1 сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчлэх ёстой нөгөө Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд байгаа. Энийгээ буцаагаад хүчингүй болгох ийм хууль оруулж ирсэн. Тэгэхээр энэ дээр асуумаар байгаа зүйл болохоор бид нар энийг 2025 оны 11 сарын 14-нд баталсан. Энэ үед юу гэдэг юм геополитик ч гэдэг юм уу, одоо энэ тайлбар танилцуулга дээр байгаа энэ бүх асуудлууд чинь байсан шүү дээ. Тэгээд тухайн үед яг батлах үед би өөрөө асууж байснаа ч санаж байгаа юм. Яг энийг хэрэгжүүлэх боломж чинь байгаа юм уу. Тийм ээ. Өөрөөр хэлбэл бүртгэл системчлэлийн хувьд байгаа юм уу, буцаан олголтын хувьд төсөв чинь болох юм уу, тухайн үедээ болно гээд оруулж ирээд л тэгээд л ингээд Их Хурлаараа батлаад явчихсан байдаг. Гэтэл энэ өөрөө батлаад

жил ч болоогүй, дээрээс нь хэрэгжиж ч эхлээгүй байгаа энэ хуулиа бөөн зүгээр улс төрийн пи ар болоод л хүмүүст юу гэдэг юм иргэдэд НӨАТ-ын буцаан олголт чинь 100 хувь болох гэж байна, 50 хувь болох гэж байна гээд ингэж яваад тэгээд батлуулчихдаг. Тэгээд нөгөө хууль нь хэрэгжиж эхлэхээсээ өмнө буцаад хүчингүй болгох гэдэг. Тэгэнгүүт энэ 2-ын хооронд жишээлэх юм бол юу гэдэг юм, хуулиар бол шинээр илэрсэн нөхцөл байдал гэдэг шиг тийм нөхцөл байдал юу ч үүсээгүй зүгээр л Засгийн газар, Ерөнхий сайд л өөрчлөгдсөн байдаг.

Тэгэхээр энэ өөрөө парламент чинь хуулиа батлаад ядаж тэр хууль чинь хэрэгжээд явах түвшинд байлгах ёстой. Засгийн газар жишээлбэл өөрийн гэсэн цаашаа үргэлжлэх бодлоготой байх ёстой шүү дээ. Тэгэхээр энийг яг асуултын хувьд бол яагаад, үнэхээр яг ямар тооцооллоо хийж үзээд энэ бүх буцаалтыг чинь хүчингүй болгож байгаа юм бэ. Тэгэнгүүтээ энийгээ хүчингүй болгоод, буцаан олголтлоо хүчингүй болгочоод нөгөө талдаа ХХОАТ-ын гээд ахиад баахан хөнгөлөлтүүд оруулаад ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ яг тухайн Засгийн газрын Сангийн сайдын бодлого байдаг юм уу, Эдийн засгийн сайдын бодлого байдаг юм уу. Тийм ээ. Яг энэ дээрээ ингээд татвар дээрээ очоод илүүтэй пи ар тал руугаа явах гэж байгаа юм шиг ийм шинэ содон зүйл оруулах гээд ингээд хуучин юмнуудаа хэрэгжүүлэхгүй болгоод яваад байдаг энэ зарчим чинь өөрөө яаж цаашаа үргэлжилж явах юм бэ. Тэгэхээр би бол энэ дээр тайлбарыг нь авмаар байна. Яагаад, яг ямар тооцооллоор яг одоогийн 10 сарын 1-ээс хэрэгжих боломжтой гэж үзэж байсан энэ буцаан олголтын дүн чинь ямар үнийн дүнтэй болоод 2027 оны 1 сарын 1-ээс 100 хувь 0-500 мянган төгрөгийнх дээр 100 хувь буцаалт хийж байсан энэ чинь ямар дүнтэй болоод одоо хэрэгжиж чадахгүй болчихоод байгаа юм бэ.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: НӨАТ-ын татвар маань 2025 онд 6,2 их наяд төгрөгт хүрээд, нийт төсвийн орлогын 20 хувийг энэ татвар бүрдүүлж байгаа буюу гол тулгуур 4 татварын 1 болж гарч ирсэн. Их нөлөөлөл өндөртэй. Засгийн газар НӨАТ-ын буцаалтыг 20 хувийг 50 хувь болгох хуулийг өргөн бариад, энийгээ иргэддээ худалдан авалтаар нь дамжуулаад дэмжье гэдэг бодлого орж ирсэн юм. Үүний өртөг зардал 1,8 их наяд төгрөгийн орлого НӨАТ-аас хасагдана гэсэн үг. Иргэд дээр үлдэнэ гэсэн үг. 1,8 их наяд үлдэх юм. Ийм хууль батлуулаад бид нар өргөн бариад, төсөв хэлэлцэж байхад Их Хурал дээр нөгөө багш, эмч нарын цалингийн нэмэгдэл гэдэг асуудал орж ирсэн. Улс төрийн шийдэл гарч орж ирсэн. Тэрний нэмэгдэл нь 2 их наяд даваад явчихлаа. 2027 онд бараг 4 их наяд руу очих гэж байгаа юм. Тэгэхээрээ бид нар тооцоолж байсан орлогоосоо гарах зарлагын хэмжээ нь 2 дахин нэмчихээр боломжгүй болчихож байгаа юм. Нэгэнт одоо сонголт байхгүй юу. Багш, эмч нарынхаа цалинг хасах уу, НӨАТ-ын энэ зардлыг хасах уу гэдэг дээр л ирж байгаа асуудал.

Засгийн тооцоолсон зардлаас эрс нэмсэн зардлыг Их Хурал дээр нэмэгдсэн учир шалтгаан юм. Нөгөө талаас энэ хавраас эхэлсэн энэ Ойрх Дорнодын нөхцөл байдал дэлхий нийтэд инфляцыг нэлээн өдөөж байна. Инфляцаар дамжаад манайх шиг орнуудад бол төсвийн дарамт нэлээн ачаалал орж ирж байна. Тэгээд ийм бас нөлөөллүүд орж ирж байгаа учир шалтгаан байгаад байна. Үнэхээр тухайн үед бол бид нарын оруулж ирсэн бодлого бол ингээд НӨАТ-аа 5 хувь болгочихъё доо л гэдэг бас бодол санаатай ингэж хийсэн зүйл маань гэтэл одоо огцом тэр урсгал зардлын нэмэгдэл өөрөө тэр орон зайг л байхгүй болгоод байна л даа. Тэгэхээр бидний орлогын бодит хэмжээ чинь хүрэлцэхээ болиод эхлэхээр сонголт буюу энэ хуулийг тодорхой хэмжээнд хойшлуулъя. Нөгөө талаас энэ НӨАТ-аар дамжаад энийг

хамгийн их ашиглаж байгаа нь нийт хүн амын 25 хувь энэ НӨАТ-ын үр ашгийн 75 хувийг хүртээд байгаа. Хамгийн их худалдан авалт хийж байгаа тэр бүлэг рүү их төвлөрөөд байгаа байхгүй юу. Гол нөгөө хүнс дээр худалдан авалт хийж байгаа бүлэг дээр болохоор энэ ихэнх нь НӨАТ-аас чөлөөлөгдсөн бараа байдаг болохоор НӨАТ-ын ачаалал нь тун бага очоод байдаг. Тэгэхээр зорилт талаасаа одоо бол бид нар багш, эмч нарынхаа зардлаа цалингаа нэмээд явах нь эргээд эдийн засгаа, худалдаа үйлчилгээгээ дэмжихэд хэрэгтэй гэж, тэтгэврээ нэмээд явах нь зүйтэй гэж үзэж байна шүү дээ. Тэгээд энэ НӨАТ-аа жоохон хойшлуулъя л гэдэг санаа байхгүй юу.

Тэгээд эдийн засгийн чадавхтай болоод ирэхээрээ мэдээж хэрэгжүүлэх ёстой эн тэргүүний ажил л гэсэн үг.

Н.Наранбаатар: Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Энэ дээр болохоор яг үнэхээр юу гэдэг юм яг энэ мөнгөөр энэ цалинг тавих гэж байгаа юм уу, энэ зардлыг хангах гэж байгаа юм уу гэдэг ийм асуудал байгаа гэж би бол бодохгүй байгаад байна л даа. Нөгөө талаасаа Татварын багц хууль өргөн баригдаж орж ирж байгаа. Тэн дээр НӨАТ-ын суутган төлөгчийн суурь босгыг 400 болгож нэмэгдүүлж байгаа шүү дээ. Тэр дээр чинь бас яг энэ нөгөө татварын асуудал, НӨАТ-ын татварын бас төсөвт нөлөөлөх нөлөөлөл бас гарч ирж байгаа. Тэгээд тухайн үед яг энэ 2025 оны 11 сарын 14-нд энэ хууль батлагдахад шилжилтийн үеийн зохицуулалт оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл яг тооцооллоо оруулаад энэ чинь 2026 оны 10 сарын 1-ээс 50 хувийн хөнгөлөлт, 2027 оны 1 сарын 1-ээс 100 хувийн хөнгөлөлт чинь явна шүү дээ. Тэгээд тэр үед тухайн үед жишээлбэл мөнгөний бодлого талаасаа ч тэр, инфляц талаасаа ч тэр бүх ойрын 5 жилийн мэдээллүүд чинь гарчихсан байсан. Одоо ийм гэнэтийн юу гэдэг юм инфляцын өсөлт ч гэдэг юм уу тэр юм болбол байхгүй. Тэгэхээр одоо ингээд харахаар хууль уг нь баталчихсан бол тэр хуулийнхаа хүрээнд Засгийн газар өөрсдийнхөө орлого, зарлага, төлөвлөгөөгөө гаргаад ингээд явах ёстой гэж ойлгож байгаа. Тэрнээс биш бид нар ингэж чадахгүй юм байна гээд л хуулиа өөрчлөөд байдаг бол хууль гэж байгаад яах юм.

Тэгээд дээрээс нь одоо юу гэдэг юм, бид нар ерөөсөө энэ төсөв чинь бүрдэхгүй юм байна гээд Татварын хуулиа өөрчлөөд суугаад байх юм уу. Тэгээд л татварын хуулиа нэмээд л нөгөө ард иргэд дээр очдог татварынхаа хэмжээг нэмээд л байдаг. Яагаад гэвэл бид нар өөр газраас орлого олж чадахгүй байна гээд. Үгүй ээ, тэр орлогоо тэр ТӨХК-удаас, ТӨК-удаас орлогоо нэмэгдүүл л дээ. Тэд нарынхаа засаглал юмыг сайжруул л даа. Төсөв рүүгээ тэр мөнгөө татахаа бод л доо. Тэгэхэд чинь тэнд хажуугийн параллель төсөв яваад байна шүү дээ. Тэгээд энэ болгоныгоо нэг бодлогын түвшинд янзалчихгүй тэгээд л төсөв гэхээр л татварын хэмжээ л ярьдаг.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Одоогийн бид нарын таны хөндөж байгаа НӨАТ-ын өөрчлөлт бол бид хэрэглээгээ их дэмжээд, эрэлтийг өдөөж, инфляцад өсөх нөлөө сөрөг нөлөө үзүүлнэ. Үзүүлэлт нь их өндөр гараад. Засгаас өргөн барьчихсан татварын өөрчлөлтийн хууль байгаа шүү дээ. Татварын хууль дээр болохоор аж ахуйн нэгжээ дэмжсэн, ажлын байр олгож байгаа энэ талаа дэмжсэн ийм бас өөрчлөлтийг засаг өргөн бариад, одоо хэлэлцүүлж байгаа. Гол нь бид нар айл өрхийнхөө суурь орлогыг нэмэгдэх бололцоог л нэмье гэж бодож байна.

Нөгөө талаар ёстой бодоод бодоод бодын шир 4 гэдэг шиг л ерөөсөө энэ 2-ын сонголтоо алийг хийх вэ гэдэг шиг л орж ирж байна. Багш, эмч нар, тэтгэврээ нэмэх үү, НӨАТ-ын буцаан олголтоо иргэдийн карманд үлдэх мөнгийг нэмэх үү. Тэгэхээр энэ бол Их Хурлын сонголт л доо. Урсгал зардлын энэ нэмэгдэл өөрөө төсвийн орлогыг түвшнээс давчхаад байгаа болохоор л зарим хэдийгээр хэрэгжүүлбэ гэж бодсон зарим хуулиасаа одоо татгалзах, хойшлуулах ийм саналыг л оруулж ирж байгаа байдал маань энэ. Тэгэхээр бид нар инфляцтай холбоотойгоор тэтгэврээ нэмж таарна. Төрийн албаныхаа цалинг нэмж таарна. Нөгөө талаар энэ хууль батлагдчихвал хөрөнгө оруулалт тэг болно гэсэн үг. Бидэнд 2,2 их наядын л хөрөнгө оруулалтын орон зай үлдсэн. Тэр хөрөнгө оруулалт үндсэндээ тэглэгдэнэ гэсэн үг. Тэрний цаана чинь аж ахуйн нэгжүүдийн хийж байгаа, гүйцэтгэж байгаа орон нутгийн эрүүл мэнд, боловсрол, орон нутгийн дэд бүтэц ингээд чиглэсэн томоохон хөрөнгө оруулалтын ид өрнөж байгаа ажлууд зогсчих ийм том эрсдэл гараад байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид хөрөнгө оруулалтаа явуулъя. Энэ чинь ажлын байр бий болгоно. Аж ахуйн нэгжийн орлого нэмэгдэнэ, татвар төлнө, цалин хөлс, суурь орлого дээр нөлөөлнө, гадаад зээлийн ашиглалтаа нэмэгдүүлбэ. Шууд ингээд тараадаг, хуваарилдаг халамж маягийн ийм бодлогуудыг жоохон хойш нь тавьчихъя л гэж байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Булгантуяа гишүүн асуулт асууна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурал одоо ерөөсөө бүх юмны буруутан болоод байгаа юм бол байхгүй шүү дээ. Та бүгдийн оруулж ирж байгааг л бид нар баталж байгаа. Энд нэг их өөрчлөөд, улсын төсвийн зарлагыг огцом нэмэгдүүлээд байсан зүйл байхгүй. Сүүлийн хэдэн жилд харин эсрэгээрээ зарлагаа аль болохоор бууруулъя, алдагдалгүй болъё гэх мэтчилэн санал санаачилгыг Улсын Их Хурал өөрөө гаргаж, илүү их ажил хэрэгч явж байгаа гэж бодож байгаа. Тэгээд яг үнэнийг хэлэхэд 2026 оны төсвийг батлахад 2 их наядын шинэ төсөл хөтөлбөрийг Засгийн газрынхаа насыг 4 сараар уртасгахын төлөө 2 их наядын шинэ төсөл хөтөлбөрийг тавьсан шүү дээ. Улаан, ногоон лаазаар өргөж байгаад. Тэгээд энэ бол үнэнийг хэлэхэд энэ дээр үүнийхээ хөрөнгө оруулалтыг та бүхэн маань аваад л явж байгаа байх. Тэгээд ийм үнэтэй улс төрийн сонголтыг хийчхээд одоо үүний бурууг иргэдийн карманд орох гэж байсан мөнгөнөөс хасаад утгагүй дээ уг нь. Яах вэ тэгээд цалин, тэтгэврийг бид нар нэмэхийн тулд ингэхээс өөр аргагүй гээд.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтуудаар эдийн засгийг бид нар дэмжих гэж байгаа гэж байна. Яах вэ, татварын мөнгө иргэдийн карманд үлдэхээр эдийн засаг ч гэсэн бас адилхан өсдөг. Та бүхэн маань харин Эдийн засаг, хөгжлийн яам бол юу хийх ёстой вэ гэхээр энэ 2-ын хоорондын аль нь илүү эдийн засгийг өдөөх вэ гэдгийг л тооцох ёстой. Тийм биз дээ.

Дээрээс нь нэмээд төсвийн бодлого үргэлж тэлж яваад байхаар мөнгөний бодлого ажиллах ямар ч орон зай байхгүй болчхоод байна. Үүнээс үүдээд уг нь бол ажилгүйдлийн асуудлыг хариуцах эдийн засгийн өсөлтийг зарим улс орны Төв банкны тухай хуульд байдаг. Яагаад гэвэл хамгийн том ажил олгогч хувийн хэвшил. Төр биш байхгүй юу. Төр хэдийд энийг төсвийн бодлогоороо дэмждэг вэ гэхээр эдийн засгийн маш хүнд үед төсвийн бодлого оролцож, эдийн засгаа бид нар дэмжих арга хэмжээ авахгүй бол болохгүй байна гэдэг. Манайх бол төсвийн бодлого нь дандаа хэтэрхий хүчтэй гар дүрж оролцоод байхаар эдийн засгийн бодлого

ерөөсөө ажиллаж чадахгүй. Түүнээс үүдээд зээлийн хүү маш өндөр хувийн хэвшил маань ерөөсөө ажиллаж чадахгүй ажлын байр тэнд бий болоход хүнд болчихоод байгаа юм.

Тэгээд Байнгын хорооны дарга аа, энэ санал гаргасан юм байна л даа. Одоо 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх гээд одоо энийг тойрч ярьж байгаа шүү дээ. Байнгын хороо чинь яг өөрөө хууль санаачилдаг субъект бас биш шүү дээ. Гишүүд санаачлах ёстой байхгүй юу. Тэгэхээр эндээс гишүүд маань өөрөө Нэмэгдсэн өртгийн орлогын албан татварын тухай хуулийг хэрвээ та санаачлах гэж байгаа бол тэр хүн санаачилна гээд бичнэ үү гэхээс биш Байнгын хороо гэхээр энэ бүх хүмүүс хамтдаа санаачлах болчихоод байна шүү дээ. Хууль дээр хууль тогтоомжийг Улсын Их Хурлын гишүүн, эсхүл Засгийн газар, эсхүл Ерөнхийлөгчийн санаачилж орж ирнэ шүү дээ. Тийм биз дээ.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Би Улсын Их Хурлын зөв буруугийн асуудлыг ердөө хөндөөгүй. Засгийн газар Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийг л мөрдөж байгаа. Баталсан зардал маань орлогоосоо даваад байна. Хөрөнгө оруулалт эрсдэлд орох нь ээ. Гадаад зээлийн ашиглалтаа нэмэхгүй бол эдийн засгийн эрэлтийг дэмжих өөр бодлогын арга хэмжээгүй болчихлоо. Алдагдлаа 1,5 хувьдаа оруулъя. Үүгээрээ эдийн засаг, үйлчилгээний салбараа дэмжье гэдэг л бодлогууд шүү дээ. Мэдээллүүдийг л өгөөд байгаа байхгүй юу. Эрсдэлийг тооцлоо. Нөхцөл байдал ингэж өрнөж байна. Одоо энэ дээр Улсын Их Хурал шийдвэр гаргаач, тэр гарсан шийдвэрийг Засгийн газар биелүүлэх үүрэгтэй ингээд л явдаг шүү дээ. Энэ дээр зөв буруугийн асуудал ердөө байхгүй. Урсгал зардал огцом нэмэгдсэн бодит ачаалал нь төсвийн орлогоосоо давчхаад байна. Зардлаасаа даваад санхүүжүүлж болохгүй байна. Энэ НӨАТ-ын буцаан олголтын хуулийг хэрэгжүүлэх үү, цалин тэтгэвэр дээрээ анхаарах уу. Хөрөнгө оруулалтаа зогсоох уу. Энэ 3 сонголтыг л эдийн засгийн нөхцөл байдал ийм байна. Энэ дээр сайн хэлэлцээд, шийдвэр гаргаад өгөөч л гэж байгаа зүйл шүү дээ. Тэрнээс энд бол Их Хурлын буруугаас болоод Засгийн газрын буруугаас болж байгаа зүйл алга. Үнэхээр төсөв, эдийн засгийн огцом төсвийн дарамтууд энэ инфляцтай холбоотойгоор, Ойрх Дорнодын нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийгээрээ л ийм нөхцөл байдалд орж, дэлхийн улс орнууд хариу арга хэмжээгээ төлөвлөөд, төрөл бүрийн бодлогуудыг, янз янзын бодлого, арга хэмжээг л хэрэгжүүлж байна шүү дээ бүгдээрээ. Тэгээд манай хэрэгжүүлэх бодлогын эхний түвшинд энэ 3 зүйл төсвийн хүрээг дагуулаад, 2 хууль орж ирж байна. Харьцангуй нөгөө экспорт маань бас овоо боломжийн. 1 үеэ бодвол ноднингийн мөн үеэсээ овоо биет болон үнийн дүнгээр овоо яваад, эвтэйхэн бас тоон үзүүлэлт гараад байна. Шатахуунтай холбоотой үүсэх эрсдэлийг нэлээн бууруулаад, тогтворжуулаад, нөөц бүрдүүлээд эхэлж байна. Тэгэхээр бид бас жаахан ажиглаж л байна л даа. Тэрнээс анхны хувилбар бол яаралтай 1 удаагийн ковидын үеийн хууль шиг эрсдэлийг даван туулах ийм хуулийн төслийг бас бэлдсэн байсан. Бас нэлээн хүлээж байна. Одоо энэ асуудал шийдэгдчих болов уу гэж бас хараад, нөлөөллийн судалгаануудыг бүгдийг нь хийгээд л байж байна. Шаардлагатай бол төсөв өргөн барих бас бэлэн байдлыг хангаж, төсвийн тодотголын тооцоог бэлдэж байна.

Н.Наранбаатар: Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Өнгөрсөн бид нарт ер нь бол энэ төсвийн сахилга батыг сайжруулах дээр өмнө нь нэлээдгүй ажлууд хийсэн юм. Одоо бид нар бол Улсын Их Хурал дээр орлогыг нэмээд байгаа зүйл байхгүй. Зарлага бид нар хамаагүй нэмж чадахгүй. Алдагдлыг угаасаа бид нар нэг их нэмээд байгаа зүйл байхгүй. Эсрэгээрээ бид нар алдагдалгүй төсөв баталъя гэж ганц хоёрхон жилийн өмнө ярьж байсан. Тэгэхээр Улсын Их Хурал дээр зарлагыг ингээд хамаагүй нэмээд, үүнээс үүдээд ийм арга хэмжээ авахаас өөр аргагүй болоод байна гэдэг ийм юм яриад байгаад чинь л эмзэглээд байгаа байхгүй юу. Бид нар зарлагыг чинь хамаагүй нэмээд, алдагдлыг хамаагүй нэмчихсэн зүйл байхгүй. Угаасаа энэ хуулиараа хориотой байхгүй юу. Тийм биз дээ. Энэ манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн нь сууж байгаа. Үүнийг бид нар бүүр тэр битгий хэл Үндсэн хуульд хүртэл зарим 1 төсвийн сахилга баттай холбоотой зүйл заалтыг хийж өгсөн. Тэгэхээр Улсын Их Хурал дээр үүнийг та бүхэн замбараагүй зарлагыг нэмээд байгаа болохоор ийм зүйл болоод байгаа юм гэж битгий яриач. Бид нарт тийм бараг эрх мэдэл байхгүй болтол төсвийн сахилга батыг аминдаа уг нь сайжруулсан.

Харин юу болоод байна вэ гэхээр улс төрөө дагаад хөрөнгө оруулалтыг жишээлбэл сая 2025 оны 11 дүгээр сард 2 их наядын төсвийн шинэ хөрөнгө оруулалтуудыг Улсын Их Хурал дээр тавьсан. Засгийн газрын насыг 4 сараар уртасгах гэж. Иймэрхүү юмнууд дээрээ харин бодитоор хэлэх хэрэгтэй.

Дээрээс нь нэмээд тухайн жил төсөв орж ирж байхад би хүртэл хэлж байсан юм. Үгүй ээ, энэ цалин тэтгэврээ тавихгүйгээр аягүй хэцүү шүү дээ. Инфляц аягүй өндөр байхаар байна. Иргэдийн амьжиргааг дэмжих ёстой шүү дээ. Тэгээд тавихгүй Засгийн газар өөрөө орж ирчхээд сүүлдээ нийгмийн юунд багш нарын жагсаал цуглаанаас үүдээд, энд зарим нэг төсвийн зохицуулалтыг хийхээс өөр аргагүй болсон. Эхнээсээ зөв төлөвлөөд л оруулж ирэх ёстой байсан шүү дээ уг нь. Нөхцөл байдал угаасаа л ийм байгаа. Ахмадын тэтгэврийг бол .../минут дуусав/

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Багш, эмч нарын цалин Засгийн газраас өргөн бариагүй. Их Хурал дээр хэлэлцүүлгийн явцад нэмэгдсэн зардал. Томоохон ачаалал. Зөвхөн ноднин гэхэд 155 төсөлд 2,4 их наяд төгрөгийн төсвийн өртөгтэй төслийг Их Хурлын гишүүд Засгийн газрын өргөн барьсан төслөөс гадуур нэмсэн байгаа байхгүй юу даа. Одоо энэ жил ч гэсэн адилхан 2027 оны жилийн төлөвлөгөө хэлэлцэж байна. Одоогийн байдлаар 1 их наядыг давсан санал гаргаад, хураалгаад л явж байна. Тэгээд энэ асуудал маань өгөөд төсвийн тогтвортой байдал нөгөө хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулиа зөрөөд, нөгөө эдийн засгийн үндэслэлтэй, ТЭЗҮ-тэй, эх үүсвэртэй хэрэгжих эх үүсвэр үр ашигтай байх талаа алдаад, тэгээд нөгөө хэрэгжилт эргээд дутуу гардаг, бага гардаг, өөрчлөлттэй гардаг асуудал дээр шүүмжлэлтэй байдал үүсдэг. Тэгэхээр энэ сая хүртэл төсвийн орлогыг 6 их наядаар хасна гэж оруулж ирээд, харин гишүүд маань та нарт их баярлалаа. Дэмжсэнгүй. Ийм мэтийн Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулаад энэ төсөв, санхүүтэй, татварын орчинтой холбоотой асуудлыг жоохон мэргэжлийн Байнгын хороод нь төвлөрч ажилладаг ийм болгохгүй бол бас арай л хэтэрсэн л дээ. Тэгэхээр энэ жилийг аль болох энэ асуудлыг давтахгүй байх талаас ингээд явж байна. Төсвийн хүрээ бол их сайн гарч байна.

Одоо хөгжлийн бодлого дээр бас ингээд санал хураалгаж байгаа байдал бол 1 их наяд гээд аваад явж байна. Энэ дээр бид нар байр суурь, хуулийг тайлбарлана, ойлгуулна. Нэгэнт бид нар чинь энэ 5 жилийн тогтвортой хөгжлийн бодлоготой,

энийгээ хаана хаанаа сахиж биелүүлэе. Тэндээ уялдаж жилийн төлөвлөгөө гарна, төсвийн хүрээнд тэрийгээ хязгаарлана. Түүнд нь Сангийн яам төсвөө зохиож хуваарилалтаа хийдэг гээд харьцангуй бас нэг үеэ бодвол овоо л болоод байна шүү дээ. Тэгэхээр энийгээ хаана хаанаа хичээгээд явчихвал энэ төсвийн сахилга бат, бодлогын хэрэгжилт хангагдаад 2 талаасаа нийлээд л явчих байх.

Н.Наранбаатар: Булгантуяа гишүүн тодруулна.

Х.Булгантуяа: Төсвийн зарлагаас гадуур нэмчихсэн зүйл байхгүй шүү дээ. Төсвийн зарлагаас гадуур нэмнэ гэж угаасаа байхгүй байхгүй юу. Одоо бид нар харин төсвийн зарлагаасаа гадуур болох гэж байгаа зүйл нь энэ гадаадын хөрөнгө оруулалтаас, гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой энэ хуулийн зүйл заалт байх шиг байна.

Та бүхэн эхнээсээ инфляц 2026 онд нэлээдгүй нэмэгдэхээр байна гэж ярьж байхад ахмадын тэтгэврийг угаасаа инфляцтай уялдуулж нэмэхээр 2023 онд Нийгмийн даатгалын багц хуулийг батлахдаа би тухайн үед сайд байсан юм. Батлахдаа жил болгон инфляцтай уялдуулж, тэтгэврийг нэмнэ гээд хуульчилчихсан юм. Төрийн албан хаагчдын цалин бас инфляцтай тодорхой хэмжээгээр уялдуулаад, нэмэгдүүлээд ороод ирэхгүй яасан юм бэ. Сүүлдээ энэ ордны гадаа, Сүхбаатарын талбай дээр багш нар, эмч нар жагсаад, ажил хаяна гээд ингэсэнд Улсын Их Хурал арга хэмжээ авахаас өөр арга байхгүй шүү дээ. Одоо ингээд арга хэмжээ авсан чинь та нар өөрснөө төсвөөс гадуур зарлага нэмж, цалин нэмээ биз дээ. Одоо үүнээс чинь үүдээд НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэх хуулиа хүчингүй болгохоос өөр аргагүй боллоо гэж тэгвэл тайлбарлаж байгаа юм байна. Би тэгж ойлголоо.

Харин эсрэгээрээ 2 их наядаар шинээр төсөл хөтөлбөрүүдийг шинээр тавиад төсвөө баталсан улс төр дагуулаад. Тэгээд дараа нь тайлбарыг энэ бол Улсын Их Хурлын хийсэн ажил. Та нарын хийснээр бид нар хийж байна шүү дээ гэж та нар хэлж болохгүй шүү дээ. Тэгээд яах юм. Багш нар нь ажил хаячихсан байж байхад бид нар багш нарын цалинг нэмэх ёстой гэдэг шийдвэр гаргахаас өөр арга байхгүй шүү дээ. Та нар өөрсдөө тэрийг Засгийн газар шийдээд, оруулаад ирэх ёстой байсан шүү дээ эхнээсээ. Баахан хэдэн мянган км зам тавихаар тавьчихаад, багш нар нь ажил хаячихсан байж байхад Улсын Их Хурал зүв зүгээр сууж байх ёстой байсан юм уу. Одоо тэгээд хэлэхээрээ та нар улс төржиж, Улсын Их Хурал дээр хэрэггүй зардлыг төсвөөс гадуур тавиа биз дээ гэдэг .../минут дуусав/

Н.Наранбаатар: Үг хэлчихсэн үү. Жавхлан гишүүн асуулт асууна.

Б.Жавхлан: Дагасан 2 хууль дээр 1-ийг нь бол бүрэн дэмжиж байна. Тэр төсвийн хүрээ баталснаас хойш 3 сараас доошгүй хугацаанд тодотгол хийж болохгүй гэдэг бол амьдрал дээр үнэхээр болохгүй байгаад байгаа юм. Тодотгол гэдэг чинь өөрөө нөгөө тодорхойгүй байдлаас үүсдэг шүү дээ. Гэтэл тэрийг нь 3 сарын дотор тодорхойгүй байдал үүсэж болохгүй гээд ингээд заачихаар амьдрал дээр үнэхээр болохгүй байгаа юм. Энийг бол ингээд дэмжинэ.

2-т нь тэр Энхбаяр сайд аа, тэр НӨАТ-ын нөгөө багц хуулиа татаж авсан. Тэгэхдээ энэ дээр чинь өмнө нь хуулиа өргөн барихад та ч гэсэн энэ ажлаа хийж байсан. Зүгээр миний бодлоор ингэчихгүй яав даа гэж 1 санаа хэлэх гэсэн юм. Бодлогоо хамгаалж үлдээд, хэрэгжих хугацааг нь хойшлуулж болох байсан байхгүй юу. Бүр 2030 он хүртэл ч хэрэгжих хугацааг нь хойшлуулж болно шүү дээ. Энэ чинь

өөрөө маш их хэлэлцүүлэг хийсэн. Олон нийтийн дунд маш их хүлээлт үүсчихсэн ийм асуудал байхгүй юу. Тэгээд энэ чинь өөрөө суурь нөгөө 10 хувиа бол хөндөөгүй шүү. Та түрүүн 10-ыг 5 болгох гэж байсан гэж яриад байх юм. Үгүй. 10 бол хэвээрээ л байгаа. Буцаан олголтын 20 хувийг 50 хувь болгох гэж байгаа асуудал байхгүй юу. Орлоготой нь уялдуулж, шат дараатай OCD-н бүх орнууд энэ рүүгээ шилжиж байгаа юм. Тэгэхээр энэ татварын яг энэ суурь реформын шинжтэй бодлогоо хадгалж үлдээд, хугацааг нь хойшлуулчихъя гэхээр одоо өнгөрсөн үү. Тэгэхээр уг нь бодлогоо бид нар чинь энэ 4 жил дотор Засгийн газар солигдсон ч гэсэн уг нь мөрийн хөтөлбөр дотор чинь ч гэсэн байгаа асуудал бодлогоо хамгаалж үлдээд, тэгээд энийгээ уг нь ярих юмтай ингээд байж байвал уг нь зүгээр байсан юм. Энийг та яг юу гэж үзэж байна.

Яг татварын бодлогын хувьд танд эргээд таалагдахгүй болчихсон уу, бодлогоосоо татгалзчихаж байгаа юм уу. Та ганцхан орлого талаас нь тайлбарлаад байх юм. Энэ жилийн орлогыг бол ойлгож байна. Тэрийг бол зөвшөөрч байна. Энэ жилдээ бол болохгүй эргэж болохгүй бас ийм бодит нөхцөл байдал үүсэж байгаа юм. Гэхдээ бодлогоо яах юм бэ. 1-д.

2-т тэр нөгөө 45-ыг уг нь 50 болгохгүй Эдийн засаг, хөгжлийн яам бол Сангийн яамыг бол ойлгож болно. Энийг жоохон нэмээд өгөөч гэж байгаа байх. Харин Эдийн засаг, хөгжлийн яам бол энийг 45 дотор, бүр 40 рүү зүтгүүлж байх ёстой л ийм яам шүү дээ. Макро бодлого талаасаа бол. Одоо энэ өнгөрсөн үү Наранбаатар дарга аа. Энийг зарчмын зөрүүтэй санал гаргаад, хэвээр нь үлдээвэл 45 гэж. Одоо зарчмын зөрүүтэй санал гаргаж болохгүй юу.

Н.Наранбаатар: Болохгүй. Хуулиараа 2 хоногийн өмнө.

Б.Жавхлан: Тэгэхдээ энэ нөгөө 45, 50 чинь өөрөө хаана хэрэглэгддэг вэ гэхээр яг гаднын хөрөнгө оруулагч нартай уулзахад, гадаад зээлийн өртэй холбоотой эрсдэлийн асуудлаа тайлбарлахад, нөгөө бонддоо явахад, өрийн зохицуулалтаа хийхэд хамгийн түрүүнд нэг дэх асуулт чинь яг энэ болж ирэх байхгүй юу. Тэгэхээр уг нь энийгээ яг 45 гээд дунд хугацааныхаа .../минут дуусав/

Н.Наранбаатар: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: 45 дээр тантай санал 1 байгаа юм. Сангийн яам маань тооцоолол хийгээд 45-даа хүрэхгүй давчхаад байна гэдэг асуудал яригдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр Чимэдсүрэн дарга, Дэлгэржаргал дарга нар яг энэ татварын ачаалалтай холбоотой, НӨАТ-ын ачаалалтай ямар эх үүсвэр яаж дутаад, яг бодит байдлаа л хэлээдэх. Зохицуулалт ийм байна. Одоо аль сонголтоо Байнгын хороо хийнэ шүү дээ. Ийм учиртай шалтгааныг нь сайхан тайлбарлаад, гадаад зээлийн ашиглалтын 45 хувь дээр тайлбарлаад, НӨАТ-ын буцаан олголт дээр эх үүсвэрийн дутах орлого нь ямар зардалтай хаана яаж нөлөөлөх гээд байна гэдэг талаасаа нэг сайхан мэдээлэл өгөөдөх.

Н.Наранбаатар: Хэдэн номер вэ. 9 номер хариулъя.

С.Тулга: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулгаа. Жавхлан гишүүний асуултад хариулъя. Энэ хүрээн дээр байгаа бол өр бол угаасаа энэ хязгаарын асуудал гэдгийг бол өмнө нь бас тайлбарласан байгаа. Тэгээд яах вэ, энэ 45-ыг яагаад 50 болгож байгаа шалтгаан нь газрын тос болон Эрдэнэбүрэнгийн зээлийн хэрэгжилт яг одоо гэрээн дээр заасан хуваарийн дагуу ашиглалтад орохоор одоо манай ДНБ-д эзлэх хуваарь энэ 45 хувиасаа хэтэрчхээд байгаа ийм л асуудал

байгаа. Тэгэхээр Засгийн газар бол жил болгон хувийн хэвшилдээ зориулж 1 тэрбум орчны баталгаа гаргах энэ орон зайгаа авч үлдэж байгаа асуудал байгаа. Хэрвээ энийг 45 руу болгоод энэ газрын тосны, Эрдэнэбүрэнгийн ашиглалт гараад явна гэхээр Засгийн газар 2027, 2028, 2029 онууд дээр хувийн хэвшилдээ зориулж Засгийн газрын баталгаа гаргах боломжгүй ийм орон зайгүй болчихоод гэсэн ийм л асуудал байгаа.

Н.Наранбаатар: 8 номер

Ч.Чимидсүрэн: Сангийн яамны Татварын бодлогын газар Чимидсүрэн. Түрүүн Энхбаяр сайд бас хэлсэн. Ер нь бол НӨАТ-ын урамшууллын буцаан олголтыг олгох юм бол 1,6-1,8 их наядын санхүүжилт бол шаардлагатай болно. Ер нь бол энэ НӨАТ-ын буцаан олголтыг энэ цаг үед шууд хэрэглэх нь бас оновчтой биш байна. Одоогийн нийгэм, эдийн засгийн ийм инфляцтай тогтворгүй байгаа үед бол иргэн, аж ахуйн нэгжийнхээ татварын ачааллыг бууруулах, иргэнийхээ орлогыг өөрт нь үлдээх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь бол зөв юм байна гээд Засгийн газар бол Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тодорхой цөөн тооны заалттай нэмэлт, өөрчлөлтийг өргөн барьж байгаа юм. Тэгэхээр энэнд бол НӨАТ-ын урамшууллын буцаан олголтоо хийж, инфляцыг өдөөхөөсөө илүү ХХОАТ дээр тодорхой тийм хөнгөлөлтийг үзүүлэх юм бол яг энэ цаг үедээ иргэндээ чиглэсэн татварын бодлогын арга хэмжээ болох юм л гэж үзээд байгаа юм.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулья.

Ж.Энхбаяр: Жавхлан гишүүний гаргаж байгаа санал их зөв. Энэ бодлогын арга хэмжээ буюу НӨАТ-ын энэ бодлогоо хадгалаад үлдэх хэрвээ бололцоотой бол Байнгын хорооны дарга аа, энэ хуулийг буцаагаад, Байнгын хорооны түвшинд дахин гүйцээн боловсруулья гэж байна шүү дээ. Янзалья гээд. Тэр хүрээндээ үйлчлэх хугацааг нь 5 жилээр хойш нь тавиад үзвэл яасан юм бэ л гээд байгаа юм. Ядахдаа энэ 3 жилээс нь мултлаад, 2033 оноос дахин энэ асуудал хөндөгдөнө гэсэн ийм бодлогоо хадгалж үлдэх нь бас их чухал. Нэгэнт баталсан нөгөө хууль байгаа болохоор бодлогоо хадгалах нь их зүгээр байж. Тэр дээр бол санал нэг байгаад байгаа юм.

Н.Наранбаатар: Жавхлан гишүүн тодруулья.

Б.Жавхлан: Тулгаа дарга аа, таны хэлсэн тоонд би арай илүү итгэе. Түрүүнд уг нь хэлтсийн дарга чинь хэлэхдээ энэ 2 зээл дээр нэмж ашиглах нь 3-4 их наяд дотор багтана гэсэн шүү дээ. Тэгэхээр ч чинь л би асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр 45 дээрээ багтах юм байна гээд. Одоо гүйцэтгэл чинь 38, 39-тэй байгаа. Тэгээд 45 гэдэг чинь 5 хувийн нөөц байгаа. Дахиад 5 хувиар нэмээд, ингээд 50 болгочихоор чинь дотоодын нийт өртөг чинь 112 болчихсон үед нэмэлт та нар ямар орон зай авч байна вэ гэхээр энэ чинь 11, 12 их наядын орон зай авч байна шүү дээ. Харин тийм. Тэгэхээр наадах чинь аягүй том орон зай авчхаад, энийгээ дараа нь та нар хөрөнгө оруулагч нартаа яаж тайлбарлах юм бэ гэдгийг чинь л би уг нь туслах гээд байгаа л санаа юм. Тэгээд та нар энийг зөв талаас нь харж ойлгоорой.

Чимидээ дарга аа, орлоготой чинь уяж тайлбарлахаар бол ойлгож байна. Энэ жил бол окэй ойлгож байна. Энэ жил болбол үнэхээр энийг дийлэхгүй байх. Харин яг нөгөө бодлогын хувьд нөгөө прогрессив энэ НӨАТ руугаа ХХОАТ луугаа ч гэсэн НӨАТ руугаа. Та нөгөө 500-г 729 болгож байгаа учраас тэр дотор ингээд тэлэлт нь бас шингэчхэж байгаа юм гэж хэлэх гээд байх шиг байна. Гэхдээ тэр НӨАТ-ын багц

хууль дотор чинь орлогод нөлөөлөхгүй зохицуулалтын шинжтэй олон нийтийн хүлээлт үүсчихсэн ийм нэлээн хэдэн заалтууд байсан шүү дээ. Тэрийгээ бүхэлдээ тэр чинь хойш нь татчихаж байгаа байхгүй юу. Тухайлбал тэр нөгөө гааль дээр хил дээр НӨАТ авдгийг больё. Борлуулалттай нь уяад орлого, мөнгөн суурь дээр нь шилжүүлээд 1, 2 сарын дараа тэр НӨАТ-ыг нь борлуулалттай нь уялдуулж тайлагнахад нь авдаг больё гээд ийм зохицуулалтууд байгаа шүү дээ. Орлогод чинь нөлөөлөхгүйгээр. Хэд хэдэн бүр дахиад ч өөр заалтууд байгаа. Тэр тайлагналтыг нь өшөө хялбаршуулж байгаа гээд. Тиймэрхүү ололттой юмнууд чинь энэ орлоготой нь уялдуулсан гэдэг далбаан доор чинь аягүй том ухралт болчихлоо шүү дээ. Тэгэхээр уг нь бодлогоо хадгалж үлдээд, хэрэгжих хугацааг нь хойш нь тавиад, тэр дотроос тэр орлогод нөлөөлөхгүй хэсгүүдийг нь хэрэгжих хугацааг нь бол нааш нь татаад, хэвээр нь үлдээгээд ингээд .../минут дуусав/

Н.Наранбаатар: Санал хэллээ. Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Төсвийн хүрээтэй холбоотойгоор энэ дагасан хуулиуд дээр бас чуулган дээр байр сууриа илэрхийлсэн байгаа. Тэгээд бид нар 6 сарын өмнө баталсан хуулийг одоо бол энэ дээр нөгөө хэлэлцүүлгийн явцад бол энийг хойшлуулах боломж байхгүй л дээ. Нэг бол бид нар эндээс буцаана л гэсэн үг. Аль эсвэл Засгийн газар яг тэр дагасан хуулийнхаа НӨАТ-тай холбоотой асуудлаа татаж авна гэсэн үг. Тэгээд 2027 оны төсөв өргөн барихдаа хэзээнээс хэрэгжүүлж эхлэх юм яг тэр хугацаагаа тавиад хэрэгжүүлэхээр өргөн барихгүй бол энэ нөгөө прогрессив татвартай холбоотой асуудлыг чинь бид нар бол үндсэндээ 2025 он бүтэн жил хэлэлцүүлэг хийгээд, судлаад, тэгээд энийг чинь оруулсан шүү дээ.

Тэгээд бид нар бол НӨАТ дээр асар олон давуу тал бий болгохоор бас татвар төлөгч нарт хөнгөлөлт үзүүлэх энэ прогрессив такс чинь эргээд яг тэр нөгөө худалдан авагчийн өрхийн орлогоос нь хамааруулж, хөнгөлөлтүүдийг нь олгодог байх, аж ахуйн нэгжийн тэр нөгөө шууд бэлэн мөнгөөр гарч байгаа урьдчилж НӨАТ-ын татвар гарч байгаа юмыг нь хойшлуулж өгөх, хөрөнгө оруулалт хийж байгаа бол үл хөдлөхийн НӨАТ-аа шууд одоо хасагдуулалт хийдэг болгох гээд асар олон өөрчлөлт орсон байхгүй юу. Тэгээд яах вэ, одоо бол энэ Татварын багц хууль дээр бол тэр юмнууд бол хасагдсан байна лээ. Тэгээд гар дээрээс худалдаа хийж байгаа худалдаачдын и-баримт өгөөд л тэрийг шууд НӨАТ-тай дүнд тооцдог болгох энэ өөрчлөлтүүд чинь эргээд тэр дунд шатын ЖДҮ, хүнсний үйлдвэрлэл эд нар чинь асар их хувь нэмэр болохоор байсан шүү дээ уг нь. Тэр хүнсний үйлдвэрлэгчдийн хүсэлтээр тэр зохицуулалтуудыг оруулсан байхгүй юу. Тэгээд тэрийгээ ингээд бүгдийг нь байхгүй болгочихсон байна лээ л дээ. Тэгээд уг нь бол энэ чинь бодлогын юмаа бол би Жавхлан сайдтай бол яг санал нийлж байна. Хэрэгжүүлэх боломжтой хугацаагаа тавиад, хойшлуулдаг бол хойшлуулаад, гэхдээ яг энэ ЖДҮ-лэлээ хөгжүүлэх, үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлэх, тэр нөгөө малчдын гар дээрээс худалдаа хийж байгаа тэр арилжаа наймааг нь дэмжих, тэр и-баримт эд нар олгодог болно гэдэг чинь үндсэндээ бол энд бүртгэлийн шинж чанар агуулж байгаа байхгүй юу. Эргээд энэ буцаалт дээр нь бид нар прогрессив оруулаад ирэхээр чинь эргээд тэр нөгөө НӨАТ төлөгч болох сонирхлоо нэмэгдүүлэх, сонирхлыг нь нэмэгдүүлэх ач холбогдолтой гэдгийг та бүхэн маш сайн мэдэж байгаа шүү дээ. Тэгээд яг тэр урагшаа алхъя, бодлогын дагуу татвараа зөв болгоё гэдэг юмаа бүгдийг нь ингээд баллуурдаад л оруулаад ирсэн байна лээ. Тэгэхээр энэ дээрээ нэг жоохон эргэж хармаар байна.

Нэг бол одоо бид нар Их Хурал дээрээс энийг нь буцаагаад, та нар тэр 2027 оны төсвөө өргөн барихдаа энийгээ хойшлуулъя гэдэг юм уу, яадаг юм ингээд

явахгүй бол яг нөгөө урагшаа алхъя, ЖДҮ-лэлээ хөгжүүлэе, НӨАТ-аа бүртгэлийн шинж чанартай болгоё гэдэг юмнуудаасаа л ухарчихсан байна лээ л дээ. Тэгээд энэ дээр би нэг тодруулга авчихмаар байна.

Н.Наранбаатар: Үг хэлчхэв үү. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ хууль маань 2026 оны 10 сарын 1-ээс хэрэгжээд эхэлнэ. Төсөв хэлэлцэж байх үед энэ чинь хэрэгжчихсэн байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээрээ бид нар төсвөө яаж өргөн барих юм. Орлого баталгаажуулж болохоор энэ хууль хэрэгжиж байгаа болохоор орлогоо бид нар баталгаажуулж чадахгүй, үүнтэй холбоотой зардал буураад гараад ирнэ. Ингээд төсвийн хүрээнд бол их том маргаан, хэлэлцүүлэг өрнөөд явчихна шүү дээ. Бүр нийгмийн асуудал руугаа ороод явчихна. Тэгэхээр яг энэ Байнгын хороо, мэргэжлийн Байнгын хороо яг мэргэжлийн дүгнэлт гаргаад, эрсдэлийг нь сайн тооцоод ингээд 1 шийдвэр гаргаад, эндээ 1 хагалаад явах нь их чухал байгаа юм. Нөгөө дагасан 3 сарын хууль бол нөхцөл байдал хүндэрвэл засгийн хурдтай шуурхай хариу арга хэмжээ авах бололцоог нээгээд, төсвийн тодотгол хийх эрхээ засаг авъя л гэж байгаа юм. Ийм 2 зүйл байгаа.

Тэгэхээр Нараа дарга аа, Ганхуяг гишүүн ээ, ингээд төсвийн үед өргөн барина гэхээр оройтчих асуудал үүсэж байна л даа. Хууль нь энэ 2026 оны 10 сараас үйлчлэл явчихна.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Тодотгол өргөн барих уу. Одоо бол энэ чинь төсвийн алдагдал чинь 1,4 болоод, дээрээс нь сая багш, эмч нарын цалин гээд автоматаар 1,7 их наяд дутагдахаар болж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь бол ингээд өссөн дүнгээрээ явсаар хэд дээр очих юм байгаа юм. 3,1 рүү бараг дөхөх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээрээ төсвийн тодотголоо өргөн барихаар бол төсвийн тодотголтойгоо хамт эсвэл энэ НӨАТ-аа хамт өргөн баривал яадаг юм. Хойшлуулах байдлаар. Тэгэхгүй бол энэ чинь бид нар бүтэн жил яалт ч үгүй хэлэлцүүлэг хийгээд явчихсан, тэгээд OCD-тэйгээ уулзсан, гадаадын туршлагыг судалсан, тэгээд хамгийн зөв хувилбар нь энэ байна гээд баталсан юмаа өнөөдөр больё гээд явж байж болохгүй л дээ.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн асуулт асууна. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Засгийн газар тодотгол өргөн барих хувилбарыг бэлдэж байгаа. Гэхдээ тодотгол маань 2026 оныхоо орлого, зарлагатай холбоотой явна. Одоо бид төсвийн хүрээ буюу энэ чинь 2027 онд үзүүлэх ачааллыг тооцоод байна шүү дээ. Орлого, зарлагатай холбоотой. Тэгэхээр энэ асуудал тодотгол дээр яригдахгүй болчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр яг одоо хамгийн хэлэлцэх яг бодит хуульд заасан яг хэлэлцүүлгийн үед нь энийгээ ярилцаад ард нь гарчихвал хамгийн зохистой нь энэ одоо л байгаа юм л даа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Энэ төсвийн хэлэлцүүлэгт дагаж орж ирж байгаа 2 хуулийн 1-ийг нь дэмжиж байгаа, 1-ийг нь дэмжихгүй байгаа байр сууриа би бас 5 сарын 14-ний Улсын Их Хурлын чуулган дээр хэлсэн. Ер нь бид нар ингээд өчнөөн хэлэлцүүлэг болж болчхоод, 1 хууль баталчхаад, тэгээд 6 сарын дараа ингээд ахиад өөрчилнө гэж орж ирж байгаа нь бол үндсэндээ хэн нэгэн Улсын Их Хурлын зөв, буруугийн

тухай асуудал биш. Улсын Их Хурлыг, парламентыг муухай харагдуулж байгаа асуудал шүү. Дээрээс нь бас энд урсгал зардлын огцом нэмэгдэлд яваандаа Улсын Их Хурал буруутай болох гээд байна уу, яах гээд байна. Тэгэхээр хуулиа өөрчилж байхаар би уг нь саналаа хэлсэн дээ. Төсвийнхөө тодотголтой цуг асуудлуудаа нэгмөсөн оруулаад ир. Тэр цалин хөлснийхөө сан энэ чинь одоо ингээд НӨАТ-ын асуудал, бусад энэ багш, эмч нарын цалинг зөвхөн ингээд ярихаар бусад нөгөө соёлын төв, бусад салбарынхан бас яриад эхэлнэ шүү дээ. Тэгээд тэр үед нь хэдүүлээ яах юм бэ гэдэг асуудал байгаа байхгүй юу.

2 дахь асуулт нь түрүүн эртээдийн чуулган дээр нөгөө бүтэлгүй төрийн будилуу сайд гээд буруу ойлгуулчихсан юм шиг байна лээ. Яг үнэндээ энэ чинь тухайн үеийн Боловсролын яамыг удирдаж байсан хүний алдаатай бодлогод гарсан шүү дээ. Та нар өөрсдөө мэдэж байгаа шүү дээ. Тэгээд 1 хүний алдаа 3 талт хэлэлцээр дээр 1 үсэг оруулахад ямар их буруу төсөв дээр ачаалал ирдгийг ингээд харж байгаа байхгүй юу хэдүүлээ. Тэгээд энэ чинь бүр парламентыг хүртэл муухай харагдуулж эхэлж байгаа юм. Хуулиа өөрчилж байснаас тэр хэлэлцээртээ гар хүрч болдоггүй юм уу. 3 талт хэлэлцээртээ. Тэгвэл арай амар ажил биш үү. Боловсролын яам. Үгүй ээ, нээрээ энэ чинь бүр толгойны өвчин боллоо шүү дээ.

2 дугаар асуудал нь яах вэ, энэ ТӨК өмч хувьчлалынхаа асуудлуудыг яаралтай оруулаад, тэндээс бас жоохон орлого олох юм байгаа биз дээ. Энийгээ хэзээ оруулж ирэх юм. Энэ 2 асуулт дээр хариулт авчихъя.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: ТӨК-ийн хувьчлалын асуудлыг 1 оруулсан, Их Хурал буцаасан. Энэ жил намар төсөвтэй холбоотой ахиад л оруулж ирнэ. Ер нь төрийн өмчийн менежментийг сайжруулах, үр ашгийг сайжруулах, нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах гээд олон асуудал байгаа. Төрийн өмчийн аж ахуйн нэгж тойрсон өр авлагын сүлжээнээс авхуулаад хэт засгаас үнэ барьж байгаатай холбоотой эрчим хүчний салбарын гинжин үүд дамжсан өр авлага, салбарын өрийн хөгжилд нь сөрөг нөлөөлж байгаа гээд олон асуудлууд байгаа. Тэгээд 1 талаас нь хөөгөөд л ажлууд явж л байна. Энэ хавартаа бол орж ирэхгүй. Хэлэлцэх асуудалд байгаа. Намрын чуулганд энэ орох байх гэж бодож байна.

Тэгээд энэ чинь 2027 оны төсвийн хүрээний дотор нөлөөллийг яриад байгаа болохоор тодотголоор болохоор 2026 оны орлого, зарлага дээр тохиргоо хийх асуудал ярина шүү дээ. Тэгэхээр тэнд ярьж болохгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр одоо ярих гол цаг хугацаа нь бол энэ. Хуулиар Их Хурлын хийх гол цаг нь бол яг энэ 6 сарын 1-ний дотор хэлэлцээд, шийдэх ёстой.

Н.Наранбаатар: Очирбат гишүүн асуулт асууна.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөө зөвлөмжийг манай сайд, дарга нар уншсан уу. Дагаж орж ирж байгаа 2 хуулийг чинь би бүр ингээд харуулъя даа. Төсвийн тогтвортой байдлын газраас гаргасан зөвлөмж, дүгнэлт.

Дүгнэлтийн 4.4 дээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд дутуу, буруу томъёололтой хэвээр байна гэж байгаа юм. Ингээд 2010 оноос 2025 оны хооронд Төсвийн тухай хууль 71 удаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 22 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь эдгээр хуулиудын хооронд

уялдаа, нэмэгдэл байдал болон зохицуулах чадварт нь сөргөөр нөлөөлж байна. Төсвөө хүрээ нь дагадаг. Тодотгол хийн төсвийн орлого, зарлага буурсан үед ч хүрээ нь хөндөгддөг нөхцөл байдалд хүрсэн байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл өөрөө Их Хуралд ажиллаад тайлагнадаг. Мэргэжлийн эксперт, эдийн засагч нар ажиллаад дүгнэлт, зөвлөмжөө өгөөд байхад энийг нь авч хэрэгжүүлээч ээ.

2 гэх юм бол НӨАТ-ын тухай хуулийг үгүй ээ энэ чинь нээрээ арай чүү нэг юм баталсан шүү дээ. Батлаад 2026 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжих ёстой байсан. Хэрэгжих ёстой байтал одоо улсын төсөв хүндрэх нь. Багш, эмч нарын цалин хэцүүдлээ. Бид нарт аравхан сарын хугацаа өгөөч ээ гэсэн. Тэгээд 2026 оны 10 сарын 1-ний өдрөөс хэрэгжих ёстой байтал одоогийн гүйцэтгэх засаглалын дарга нар, сайд нар ажлаа хийгээгүй шүү дээ. Та нар бид нарт хугацаа өгчих өө, энэ хугацаанд сайжруулж орж ирээд, ажлаа зөв төлөвлөөд, цаашаа явчихъя л гэж хугацаа авсан. Тэгээд өнөөдөр хугацаа аваагүй шууд хуулийн хулгай хийж, 2027 оны төсвийн хүрээ, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг дагуулж орж ирээд хүчингүй болгох гэж байна шүү дээ. Энэ чинь дунд болон дунджаас доошоо орлоготой иргэдийг дэмжиж байгаа юм. Нийт зах зээлээ тэлж байгаа юм. Далд эдийн засгийг ил болгох гэж байгаа юм. Иргэдээрээ дамжуулж, бүртгэлийн системээрээ дамжуулж ил болгох гэж байгаа юм. Тэгээд 0-500 мянган төгрөгийн худалдан авалт хийхэд нь татварыг нь 100 хувь буцаагаад өгчхөж болдоггүй юм уу НӨАТ-ын нь. 500-1 сая төгрөг болохоо 50 хувийг нь, 1 сая төгрөгөөс дээшээ тэр үнэтэй юм хэрэглэдэг хүмүүс нь хамаагүй хуучнаараа татвараа төлчихье гэсэн ийм бодлого орж ирсэн. Тэгээд Энхбаяр сайд аа, та өөрөө энэ Засгийн газруудад дамнаж ажиллаж байгаа хүн. Энэ бодлогыг бас хэлэлцсэн л хүн. Тэгээд өнөөдөр бодлогынхоо эсрэг зогсож байна гэдэг бол харамсалтай санагдаж байгаа юм.

Тэгээд 1 минут нэмээд авчих уу дарга аа.

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье.

Г.Очирбат: Энэ 7 хоногийн 1 дэх өдөр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөнтэй уулзаж, энэ талаар мэдээлэл авсан. 1-т.

2-т гэх юм бол энэ гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх анхдагч хуулийн төсөл дээр бас мэдээлэл авсан. Энийг бас Ж.Энхбаяр сайд та дүгнэлтийг нь уншсан уу. Би 2 заалтыг уншиж үзүүлье дээ.

Энэхүү хууль батлагдвал төсвийн тогтолцоо эрх зүйн орчинд томоохон сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд 2 төсөвтэй болох, төсвийн алдагдлыг төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хүрээний хязгаарлалтаас гаргах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн бодлогын ач холбогдлыг сулруулах зэрэг үр дагавар гарахаар байна гэж байгаа юм. Юу хэлэх гээд байгаа юм гэхээр гүйцэтгэх засаглал энэ Их Хурлыг ингэж муухай харагдуулахаас илүүтэйгээр мэргэжлийн экспертүүдийнхээ зөвлөгөөг ав. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн жил болгон зөвлөгөө өгдөг, дүгнэлтээ боловсруулдаг. Энийг нь хийдэггүй. Тэгээд энийгээ болих хэрэгтэй шүү дээ.

Тэгээд бид нар одоо мөнгөгүй байна гээд байдаг. Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ дүгнэлтийн 1 дээр төсвийн .../минут дуусав/

Н.Наранбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй Эдийн засаг, хөгжлийн яам төсвийн хүрээ оруулж ирэхийн өмнө бол байнга уулзаж, тоонуудаа нийлүүлж, мэдээлэл солилцож орж ирж байгаа. Арга аргачлалын хувьд зөрөөд байгаа юм ердөө байхгүй. Энэ сайжруулах ёстой зүйл бол хуулийн өөрчлөлтүүдийг л яриад байгаа юм. Энэ 9 тооны хүрээнд төсвийн хүрээ биш энэ дээр бусад тусгах ёстой бас 4, 5 үзүүлэлтүүд байна. Энийгээ оруулж ир гэдэг л агуулга байгаа байхгүй юу даа. Тэрнээс буруу хийгээд, дутуу тооцоод байгаа зүйлийг дурдаж байгаа зүйл байхгүй. Бодлого хэвээрээ. НӨАТ-ын бодлого хэвээрээ. Гэхдээ бодлого маань хэрэгжүүлэх энэ цаг үе маань өнөөгийн энэ төсөв, санхүүгийн нөхцөл байдлын нөлөөлөлтэй холбоотойгоор хэрэгжүүлэхэд хүндрэл үүсчихлээ.

Их Хурлын гишүүд минь ээ, Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо минь ээ, хөрөнгө оруулалтаа хасах уу, цалин тэтгэврээ хасах уу, эсвэл энэ НӨАТ-ын хуулийг хэрэгжилтийг нь хойшлуулаад, үйлчлэлийг нь хойшлуулах уу л гэдэг асуудлыг өгч байна шүү дээ бид нар. Бид нарт чинь орон зайнууд хязгаарлагдмал болоод байгаа юм. Энэ дээр л мэргэжлийн Байнгын хороо дүгнэлт гаргах ёстой байхгүй юу.

Хөрөнгө оруулалтаа идэвхжүүлээд, явж байгаа хөрөнгө оруулалтаа хөрөнгө оруулалтаа идэвхжүүлэе, ажлын байрыг хадгалах нь чухал байна. Аж ахуйн нэгжүүдийг орлоготой байлгах, түүгээрээ дамжаад төсвийн орлого бүрдэх нь, ажлын байр бий болох нь, өрхийн орлого нэмэгдэх юм байна. Гадаад зээлийн ашиглалтыг сайжруулъя. Гадаад зээлийн ашиглалтыг сайжруулахын тулд батлагдсан хэмжээ чинь өнөөдрийн Нефть боловсруулах үйлдвэрийн шаардлагатай төсвүүд энэ жил санхүүжих дүнгээс давчхаад байна шүү дээ. Тэгээд тэрийг нь тусад нь гаргаад улс орны стратеги ач холбогдолтой эрчим хүч Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг нефть боловсруулах үйлдвэрийг хурдан яаралтай хийж ашиглалтад оруулах ёстой ийм л бодлого байхгүй юу.

Харин эсрэгээр нь Их Хурал Засгийн газрыг энийг дэмжиж өгөөд, шахах хэрэгтэй байхгүй юу. Нефть боловсруулах үйлдвэрээ хурдан оруул, Эрдэнэбүрэнг хурдан оруулж, баруун 5 аймгийн эрчим хүчний хараат байдлыг бууруул, үйлдвэрлэлийг дэмжих хэрэгтэй байна. Гадаад зээлийн ашиглалтаар наад бусад салбарын эрүүл мэнд, боловсролын, орон нутгийн дэд бүтцийн хөгжлийн маш олон хөтөлбөрүүд чинь орж чадахгүй хуулийн хязгаарт орчихоод байна шүү дээ. Энэ болгоныг шийдэх ийм тооцооллыг нь оруулаад Их Хуралд өгч байгаа юм. Энэ бол Их хурлын бүрэн эрх. Их Хурал нефть боловсруулах үйлдвэрийг, Эрдэнэбүрэн цахилгаан станцыг хурдан түргэн явуулахгүй. Урт хугацаанд, бага багаараа ингээд оруулна гээд шийдвэл бид нар мэдлээ гээд л явна шүү дээ. Энэ улс оронд энэ хэрэгтэй байна. Энэ чинь Их Хурлаар шийдэж байгаа асуудал. Засгийн газар шийдчихээд оруулж ирж байгаа зүйл биш байхгүй юу даа. Саналууд гаргаад байна шүү дээ. Зээлийн ашиглалтыг нэмье. Энэ нь эдийн засагт хэрэгтэй байна. Төсвийн алдагдлыг 1,5-аар нэмж байгаа нь зээлийн ашиглалтыг нэмж байгаа орон зай энэ гарч ирж байна гэж. Шийдэлтэй нь, тооцоотой нь, эрсдэлтэй нь л гаргаж өгч байгаа байдал байхгүй юу даа. Одоо энэ дээр яг дотроо хэлэлцүүлгээ хийгээд ингэе гээд л шийднэ. Одоо бид нар шийдвэр гаргах гээд байна шүү дээ.

Н.Наранбаатар: Очирбат гишүүн тодруулна.

Г.Очирбат: Ойлголоо. Тэгээд шийдэл гаргуулах гээд бид нар луу өгөөд байгаа юм байна л даа. Бид нар чинь уг нь гүйцэтгэх засаглалаа ажил хий гээд томилоод явуулаад байдаг. Ирээд Улсын Их Хуралд ажлаа тайлагна, 2027 он дараагийн 5

жилийн дунд хугацааны төлөвлөгөөгөө оруулж ирээд тэрнийх нь дагуу яв гээд байдаг. Бид юу хүсээд байгаа юм. Монгол Улсын иргэдийн авч байгаа цалин нь 20, 30 хувь өсөөсэй, 2 дахин өсөөсэй, эдийн засаг маань 2 дахин тэлээсэй, 1 хүнд ноогдох ДНБ-ийг 15 мянга хүрдэггүй юм гэхэд 10 мянгад аваасай. Бид нар энийг хийхийн тулд ийм ийм хөгжлийн төлөвлөгөө оруулаад ирлээ. Тэгэхдээ энэ бол төсвийн хүрээндээ бид өөрсдөөсөө шалтгаалах бүх ажлаа хийчихсэн. Яам, Тамгын газраа багасгачихсан, төсвийн урсгал зардлаа таначихсан, Хөрөнгө оруулалтын тухай хууль дээрээ ажиллачихлаа. Тэр уул уурхайн хуулиа оруулаад ир л дээ. Би танд зөндөө л урьд нь хэлсэн. Тэгэхгүй зүгээр бид нарт ийм байна. Та нар энийг шийдэж өг. Шийдэж өгвөл сайн, өгөхгүй бол бас сайн гэдэг хувилбараар ингэж явж болохгүй шүү дээ. Бид хөгжлийг танаас сонсмоор байна. Та Эдийн засаг, хөгжлийн сайд. Та бусад сайд нартайгаа ажиллаад, Монгол Улсын хөгжлийг хэдүүлээ 5 жилийн төлөвлөгөөтэйгөө уялдуулаад, жилийн төлөвлөгөө гаргахдаа яг энэ энийг хийвэл төсвөө хэмнэх нь. Үгүй ээ, ер нь цаашдаа бид нар энэ төсвийн алдагдалгүй л болох хэрэгтэй шүү дээ. Айл өрхөөр бол юу гэх вэ, би дугуй засвар ажиллуулдаг бол зээл аваад байдаг. Зээлдээ баригдаад байвал дампуурна шүү дээ. Тэгэхээр та тийм юм хийж оруулж ирээд, тэгээд бүр төсвөө 2 хувааж оруулж ирээд, тэгээд энэ улс эх орныг дампууруулах гээд байгаа юм уу. Яах гээд байгаа юм. Тэр чиглэл рүүгээ ороод байна шүү дээ. Танаас бид нар хөгжил сонсмоор байна. Улс эх орны ирээдүйг сонсмоор байна. Энэ ахмад багш нарын цалин нь жил болгон тэр инфляцтайгаа уялдуулаад өсөж баймаар байна. Тэрний эдийн засгийн тэлэлтийг та бодлогоор хиймээр байна. Аж ахуйн нэгжээ дэмжмээр байна. Орлоготой, мөнгөтэй болмоор байна. Тэгээд иргэдээ орлоготой, мөнгөтэй болгоё гэсэн бүх юмны эсрэг зогсдог гүйцэтгэх засаглал байна гэдэгт бол би бол хувь гишүүнийхээ хувьд харамсаж байна шүү.

Н.Наранбаатар: 5 номер.

Ж.Энхбаяр: Төсвийг ашигтай батлах, алдагдалтай батлах гэдэг маань санхүүгийн л арга хэрэгсэл шүү дээ. Алдагдлаа болохоор муу болж байгаа юм ердөө байхгүй. Жишээлбэл, танай 1 бизнес эрхэлж байна. Өдөрт мянган хуушуур зарагдаж байн. Эрэлт их байна. Тэгвэл та зээл аваад, 2000 болохын төлөө явна. Үүнтэй адилхан эрчим хүчний салбар маань дээд хэмжээнд тултал үйлдвэрлэлээ хангачихлаа. Одоо зээл аваад бид нар УЦС барья. Нүүрсний станц барья л гэж байна шүү дээ. Тэгэхийн тулд гадаад зээлээ ашиглая. Нефттэй холбоотой дэлхий нийтийн хямрал гараад байна. Манай хамгийн сул тал байна. Гаднын хамаарлыг бууруулъя. Хурдхан шиг энэ үйлдвэрээ ашиглалтад оруулъя л гэж байгаа юм. Тэгэхийн тулд яах вэ гадаа зээлээ ашиглалтаа л нэмье гэж байгаа юм. Энэ болгонд чинь л мэргэжлийн Байнгын хороотойгоо бид нар зөвлөж байна шүү дээ. Хувилбарууд гаргаад ирлээ. Ийм 1, 2, 3 ийм эрсдэлүүд үүсэж байна. Боломж энэ байна. Төсвийн орлогын хязгаар чинь энэ байна. Эдийн засгаа идэвхжүүлэхийн тулд ийм бодлогыг оруулж ирье гэж байгаа энэ 9 тооны цаана чинь дандаа тийм л агуулгууд явж байна шүү дээ.

Н.Наранбаатар: Түвшин гишүүн асуулт асууна.

Б.Түвшин: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн хүрээн дээр нөгөө асуулт асуугаагүй, үг байсан. тэгээд үггүй явчихсан учраас зүгээр хэлчихье. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл буюу энэ ирэх 3 жилийн төлөвлөгөө бол би тун тааруухан мэдээлэл байна гэж харж байна. Орлогоо өсгөсөн, зарлагаа өсгөсөн, ДНБ-д эзэлж байгаа орлого, зардал аль аль нь өссөн. Тэгээд дээрээс нь төсөв алдагдалтай гарсан. Үгүй ээ, энэ яагаад юм хийж болохоо байчихаад байгаа гэж.

Яагаад энэ төсвийн гадуур энэ хууль орж ирээд байгаа гэж. Энэ зардал чинь үр ашиггүй болоод, хуулийн шаардлагаа бөглөөд хаячихсан байхгүй юу. Тэгээд энэ үр ашиггүй зардлаа бууруулах биш маш богино хугацааны шийдвэр гаргаад, алдагдлаа нэмчхээд, дээрээс нь зарим зардлаа хуулийн гадуур гаргачихъя гэсэн ийм л төсвийн хүрээний мэдэгдэл орж ирж байгаад бол туйлын их харамсаж байна.

Одоо бол энэ 2 хуулийн тухай нэгэнт ярьж байгаа учраас энэ хуулийн тухай 1, 2 асуулт асууя.

Ер нь бол өмнөх хүчингүй болгоё гэж байгаа хууль чинь нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг буулгая гэхээсээ илүүтэй бага дүнтэй худалдан авалт хийдэг хүмүүсийн орлогыг нэмэгдүүлье гэдэг бодлого шүү дээ. Буцаалт хийчихье. Бид нар буцаагаад өгчихье. Энэ хүмүүсийн орлогыг жоохон нэмэгдүүлчихье. Энэ чинь татварын бодлогын хамгийн буруу хэлбэр шүү дээ. Авах гэж байгаа юмаа тодорхой, авах гэж байгаа субъектүүддээ шууд хандахгүй, жижиг орлоготой иргэдийн орлогыг л нэмэгдүүлье гэж байгаа чинь хурааж авчхаад буцааж өгч байгаа зардал чинь тэр өгч байгаа мөнгөнөөсөө ч илүү их болж шийднэ.

Одоо орж ирж байгаа энэ шатлалын босгыг өсгөө гэж байна. Энэ чинь 1 талдаа татварынхаа суурийг сулруулж байна шүү дээ. Ер нь бол татварын ачаалал багатай хэсэг рүү орёе. Жижиглэе. 1,2 тэрбумын орлоготой нь бол 3 хуваагдчихъя. Тэгээд ингээд жижгэрээд байх юм бол татварын хөнгөлөлт авах юм байна. Ингээд дандаа ухарсан асуудал. Гэтэл бид нарын хайгаад байгаа бодитой шийдэл бол аж ахуйн нэгжүүд дээрээ яаж бизнес эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх вэ, тэд нарынхаа ашиг орлогыг яаж нэмэгдүүлэх вэ, энэ өртөг зардлыг яаж бууруулах вэ, нэмэгдсэн өртгийн албан татвар нь өртөг зардал буураад байгаа бол нийтээр нь энэ үнийн дүнг яаж бууруулах вэ гэдэг энэ бодлогоо бодохгүйгээр иргэдийн орлогыг нэмэгдүүлэх гээд ингээд эсвэл бараг тэр халамжийн чиглэлийн бодлого руу ингээд яваад байх юм. Энэ урсгал зардал бууруулах боломжгүй л гээд тэгж байна. Уг нь болбол Засгийн газар урсгал зардлыг хамгийн ихээр бууруулах бодлого барьчхаад орж ирэх байтал зүгээр л зардлаа нэмж байна.

Би 2, 3 жишээ хэлье. 2017 онд 7 их наяд байсан. 2021 онд 12, 2023 онд 17, тэгээд үүнээс хойш 20 их наяд гараад явчихсан. Өнөөдөр бид нар 24 их наядын урсгал зардлыг юундаа ч хүрэхгүй байна гэж байна. Урсгал зардлын гол цалин гэдэг мөртөө эрүүл мэндийнхэн, боловсролын салбарынхан цалиндаа сэтгэл ханамжгүй. Энэ үр ашиггүй зардлаа 2, 3 их наядаар бууруулж орж ирээд төсвийн алдагдлаа.../минут дуусав/

Н.Наранбаатар: Үг хэлчхэв үү. Энхбаяр сайд. Сангийн яам. Мэндсайхан сайд хариулах уу. Сангийн яам. 8 номер.

Ч.Чимидсүрэн: Түвшин гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Татварын бодлогын газар Чимидсүрэн. Тэгэхээр нэмэгдсэн өртгийн урамшууллын буцаалт нь одоо 20 хувь байгаа ингээд энэ 10 сарын 1-ээс ингээд 50 хувь буюу биднийхээр бол нөгөө 2 хувь маань 5 хувь болох гээд байгаа юм. Тэгэхээр ер нь бол хэрэглээний дийлэнх нь өндөр хэрэглээтэй иргэд рүүгээ буцаан олголт нь очих гээд байгаа байхгүй юу. Би энийг зарим нэг тоогоор илэрхийлье. Бидний хийсэн судалгаагаар 700 мянга хүртэл бага орлоготой 83 мянган өрх байгаа юм. Тэгэхээр эдгээр хүмүүст бол энэ буцаалтаар очиж байгаа нь бол 37 мянган төгрөг буцчихаар байгаа юм. Гэтэл 2 сая 100 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүдэд түүнээс 3,7 буюу 135 мянгаар буцаалт нь очих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө 2 хувийг 5

болгосноор бол өндөр хэрэглээтэй, арай илүү өндөр орлоготой хүмүүстэй л буцаж очиж байгаа урамшуулал нь бас их өндөр байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ удаагийн цаг үеийн нөхцөл байдалтай холбогдоод бол хэрэглээнд нь суурилсан биш, харин хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжсэн бодлогыг нь бол дэмжье гэдэг энэ утгаар бол Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол өргөн барьж байгаа. Тэр дээрээ ХХОАТ дээр бага, дунд орлоготой иргэдээ бас дэмжих ийм бодлогыг бас оруулж ирж байгаагаар бол .../минут дуусав/

Н.Наранбаатар: Түвшин гишүүн тодруулна.

Б.Түвшин: 1 дүгээрт төсвийн орлогын талаас, 2 дугаарт нэмэгдсэн өртгийн албан татварын үзэл баримтлалын талаас, 3 дугаарт бизнес эрхлэх орчны талаас ингэж оруулж ирэхгүйгээр явсаар байгаад бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, явсаар байгаад бизнесийг хамгийн жижиг бизнесүүдийг татвар төлөхгүй болгох гэсэн ийм л үзэл баримтлал руу явчхаж байгаа байхгүй юу.

Тийм учраас одоо энэ хүчингүй болгоё гэж оруулж ирж байгаа татвар чинь ч гэсэн үзэл баримтлалын хувьд буруу. Одоо оруулж ирж байгаа татвар чинь ч гэсэн үзэл баримтлалын хувьд буруу. Тэгээд ерөөсөө энэ бизнесийн орчныг сайжруулах тухай юм ярихаа тэгвэл больчих. Одоо бага, жижиг орлоготой иргэдийг жоохон орлогыг нь нэмэгдүүлье. Эсвэл жижиг бизнесийг татвар төлдөггүй болгоё гэж орж ирэх юм бол энэ чинь харин байж болж байгаа ийм асуудал.

Төсвийн орлого талаасаа үр ашиггүй зардлаа бууруулаач ээ л гэж шахаж байгаа шүү дээ. Одоо энэ төсвийг алдагдалгүй болгоё гэдгийг буруу л юм гэж яриад байна. Хамгийн зөв асуудал. Өнөөдөр урсгал зардал чинь 7 их наяд байж байснаа 24 их наяд болчихсон. Сүүлийн 2 жилийн дотор 30 хэдэн хувиар өсчихсөн. Сүүлийн 3 жилийн дотор. Тэгээд энэ үр ашиггүй урсгал зардлаа бууруулахын оронд л буцаагаад хөрөнгө оруулалтаа багасгая. Эсвэл энэ төсвийн ДНБ-д эзэлдэг хувиа өсгөө гээд ингээд тэлэх бодлого барьж байна. Энэ бол Засгийн газар өөртөө нэг бол итгэлгүй байна. Эсвэл богино хугацаанд зарлага гаргаад явъя л гэдэг ийм л үзэл баримтлал руу орж ирж байна гэж. Энэ бол маш их харамсалтай үйл явдал болж байна гэж харж байна шүү.

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалтууд явна. Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Мандхай нараас хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирүүлсэн байна.

Саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах, үүнтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Дэмжинэ.

Энэ дэмжихгүй болохоороо хууль хоорондын техникийн бичилт хийхгүй бол болохгүй болчхоод байгаа юм байна лээ. Үзэл баримтлал энэ тэр нь хэвээрээ. Зөвхөн манай хуульчид техникийн бичилт хийх юм байна лээ. Тэгээд буцаагаад өргөн барих юм. Буцаачхаад, засаад өргөн барих юм. Зөвлөхөөс тайлбар аваадахъя.

Б.Гандулам: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Төсвийн байнгын хороо Гандулам.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.5 дээр анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэг бэлтгэхдээ хууль тогтоомжийн уялдааг хангах зорилгоор бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно гэсэн дэгийн зохицуулалттай байгаа. Үүний дагуу саяын санал хураалт явагдахаар байгаа.

Н.Наранбаатар: Ийм зохицуулалт байгаа юм байна. Тэгэхгүй бол одоогийн байгаа хууль дээрх заалт, Засгийн өргөн барьсан тэр төслийн заалт 2 нь давхардаад байгаа юм байна. Тэгээд тэрийг техникийн бичилт хийж засах юм байна. Тэгээд бусдаар өөр юу ч өөрчлөгдөхгүй. Саналын томьёолол тарааж өгсөн байх ёстой доо. Хуулийн төслийг санаачлагчид нь буцаах. Тийм ээ буцаана.

Би нэмээд тайлбарлаадахъя. Ингэж байна. Одоогийн хүчин төгөлдөр үйл үйлчилж байгаа НӨАТ-ын тухай хуулийн 15.2.1 дэх заалт нь Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслийн өөрчлөн найруулахаар хөндсөн 15.2 дахь заалт 2 нь үг, үсэг найруулга нь давхардсан байгаа. Иймээс яг адилхан үг, өгүүлбэрээ өөрчлөн найруулах хуулийн техникийн бичилт хийх болно. Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслийн зохицуулалт нь 2025 оны 11 сарын 11-нд баталсан НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болгох агуулгатай юм. Иймээс Нэгдсэн хуралдаанаас төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгтгэн нэгэнт дэмжсэн тул хуулийн зөв техникээр хуулийг батлуулахаар гаргасан санал болно. Энэ санал дэмжигдэхгүй тохиолдолд Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслөөр үлдэнэ. Энэ нь хуулийн техникийн зөрчилтэй гээд байгаа байхгүй юу манай ажлын албанаас.

39.20-д дэгийн тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томьёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураана. Тэгэнгүүт дахиад ийм саналын томьёолол Мандхай гишүүнээс ирчихсэн байгаа юм.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулах саналтай байна.

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

15.2.1.Энэ хуулийн 15.3-д заасан нөхцөл шаардлага хангасан албан татвар төлөгчийн тухайн улиралд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн албан татварын 20 хүртэлх хувийг буцаан олгох бөгөөд иргэний дотоодод үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтад төлсөн албан татварыг 100 хүртэлх хувийг буцаан олгох, өргөн хэрэглээний хүнсний барааны жагсаалт хэрэгжүүлэх хугацаа тайлагнах журмыг Засгийн газар батална гээд ийм бас санал.

Өргөн хэрэглээний хүнсний барааны жагсаалтад согтууруулах ундаа, тамхи, ресторан, нийтийн хоол, түргэн хоол болон хүргэлтийн үйлчилгээний худалдан авалтыг хамааруулахгүй байхаар журам заасан гээд Мандхай гишүүнээс ийм зарчмын зөрүүтэй санал ирсэн юм.

Тэгээд одоо санал хураалт явуулъя. Дахиад унших юм байна.

Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах, үүнтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар.

Тэгвэл дахиад тайлбарлаадахъя. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа НӨАТ-ын тухай хуулийн 15.2.1 дэх заалт нь Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслийн өөрчлөн найруулахаар хөндсөн 15.2.1 дэх заалт 2 нь үг, үсэг найруулга нь давхардсан байгаа. Үг, үсэг найруулга нь давхардсан байгаа. Иймээс яг адилхан үг, өгүүлбэрийг өөрчлөн найруулах хуулийн техникийн бичилт болно.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслийн зохицуулалт нь 2025 оны 11 сарын 14-нд баталсан НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болгох агуулгатай юм. Иймээс нэгдсэн хуралдаанаас төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь нэгэнт дэмжсэн тул хуулийн зөв техникээр хуулийг батлуулахаар гаргасан санал болно. Энэ санал дэмжигдэхгүй тохиолдолд Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслөөр үлдэнэ. Энэ нь хуулийн техникийн зөрчилтэй гэсэн. Тэгэхээр яана гэсэн үг юм. Техникийн зөрчилтэй байхаараа хэрэгжинэ гэсэн үг юм уу, хэрэгжихгүй гэсэн үг юм уу. Энхсайхан нэг тайлбар өгөөдөх. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны зөвлөх та яг мэргэжлийн талаас нь хуулийн бичил талаас нь тайлбарлаад өгөөч. Тэгэхгүй бол гишүүд улс төрийн асуудал болгоод байна. Энэ чинь 2027 оны төсвийн хүрээгээ дагаж хийгдэж байгаа болохоор төсвийн хүрээтэйгээ хамт л явах ёстой хууль байхгүй юу. Татаж болохгүй. Та нэг бичилтийг нь яагаадхаач. Ингэсэнтэй холбоотой үүсэх үр дагавар нь юу юм бэ гээд.

Н.Наранбаатар: Саналаа хураая. Дахиад уншъя.

Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах, үүнтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх. Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар санал гаргасан. Санал хураалт. 15 хүн дэмжиж, 45,5 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Мандхай гишүүний гаргасан саналаар томъёоллыг уншъя. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.2.1.энэ хуулийн 15.3-т заасан нөхцөл, шаардлага хангасан албан татвар төлөгчийн тухайн улиралд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн татварын 20 хүртэл хувийг буцаан олгох бөгөөд иргэний дотоодод үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтад төлсөн албан татварыг 100 хүртэл хувийг буцаан олгох. Өргөн хэрэглээний хүнсний барааны жагсаалт, хэрэгжүүлэх хугацаа, тайлагнах журмыг Засгийн газар батална.

Жич: Өргөн хэрэглээний хүнсний барааны жагсаалтад согтууруулах ундаа, тамхи, ресторан, нийтийн хоол, түргэн хоол болон хүргэлтийн үйлчилгээний худалдан авалтыг хамруулахгүй байхаар журамд тусгана.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт. 33 хувиар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууна. 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Үгүй ээ, энэ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд оруулж байгаа өөрчлөлтийг бид бодмоор байгаа юм. Ний нуугүй үнэнийг хэлэхэд. Мэдээж энэ татварыг хуулиудыг багцаар нь бид харах ёстой. Энэ 2025 оны 11 сард батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль бол үндсэндээ бид хэрэглээгээр нь дамжуулж, үндсэндээ бага орлоготой хэсгээ дэмжих ийм бодлогын чиглэл явчихсан юм. 2026 оны 10 сарын 1-ээс 1 сая төгрөгийн худалдан авалтад төлсөн татварынхаа 50 хувийг буцааж авахаар ийм заалт байгаа байхгүй юу. 2027 оноос 500-д төлсөн татварынхаа 100 хувь буцааж аваад, 500-1 сая болохоор 50 хувь буцааж аваад, тэгээд 1 саяас дээшхэдээ одоо явж байгаа 20-иор гэдэг ийм зарчим байсан юм. Гэтэл сая Засгийн газар өргөн барьж энэ татварын хуулиудыг багцалж оруулж ирэхдээ хэрэглээ талаас нь энэ бага, дунд орлоготой хэсгээ дэмжих юм уу, эсвэл үйл ажиллагаа талаас нь дэмжих юм уу гэж үзээд ХХОАТ-ын тухай хууль дээр 792 мянган төгрөгийн орлогыг нь ерөөсөө татвараас хөнгөлчих ёстой юм байна. Энэ нь ерөөсөө энэ орлоготой, амьжиргаатай байгаа энэ хэсгүүдийнхээ үйл ажиллагааг нь дэмжих ёстой юм байна гэдэг зарчим. Үүгээр тооцогдохоор 79200 төгрөг байхгүй юу татвар нь. Энэ нэмэгдсэн өртгийн албан татвараар болохоор зэрэг 75 мянган төгрөг байгаад байгаа юм. 500 дотроо 100 хувь буцаана гэхээр 50 мянган төгрөг, 500-1 сая доторхоо тооцохоор зэрэг 25 мянган төгрөг, ингээд 75 мянган төгрөг тэгээд энэ утгаар нь авч үзэх юм бол энэ 2 татварын хуулийн уялдаагаар бол тэр ХХОАТ-ын тухай хуульд оруулж байгаа өөрчлөлтийн орлого, үйл ажиллагаа дэмжих хэсгээр нь бол 79200 яаж байгаа учраас энд их том чанарын өөрчлөлт байхгүй яг үнэнийг хэлэхэд. Харин юм хийж бүтээх гээд байгаа хэсгээ дэмжиж байгаа ийм төрийн бодлого болж гарч ирж байгаа юм байна лээ. Би бол энэ талаас нь харчхаад ийм юм байна гэж ингэж ойлгосон юм. Мэдээж хэрэглээ талын

юмнууд байгаад байгаа. Тийм учраас хуулийн үйлчлэлийг тодорхой хугацаагаар хойшлуулж байгаа юм байна. Энэ одоо НӨАТ-тай холбоотой хуулиа гэсэн чинь хуулийн өнөө буцаан олголтын асуудлууд нь хууль дээрээ байхгүй болчихоод бүр гайхал төрүүлээд ингээд ээдрээ үүсгэхээд байгаад байсан байхгүй юу. Тэгээд сая би энэ Төсвийн байнгын хорооны даргыг энэ алдааг буюу тэр хуулийн техникийн алдаануудыг л засах гэж л зарчмын зөрүүтэй саналын томъёолол оруулж ирлээ, хуулийн төслийг нь ийш нь буцааж байгаад буцаагаад .../минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмээд 1 минут.

Ж.Батжаргал: Засалт хийх гэж байгаа юм байна гэсэн бид дэмжээгүй. Тийм учраас үүгээрээ явахаас өөр арга байхгүй. Тэгээд тэр эцсийн хэлэлцүүлэг эцэслэн батлах үйл явц дээрээ ямархуу байдлаар авч үздэг юм. Нөгөө нэг зүйл бид бас 1 юмыг зөв ойлгомоор байна. Хүнээс хэдүүлээ ийм юм хийе, надад жоохон хөнгөлөлттэй зээл өгчих гээд авчхаад, тэгээд өөрсдөө тэнэг юм шиг энийг бид 10 жилд хувааж авъя. Жилд 200 тэрбумаар гээд яриад байж болохгүй шүү дээ. Аль болохоор 3 жилд гэдэг юм уу, бүтнээр нь зээлээ аваад юмаа хийчхээд, тэрнийхээ үйл ажиллагааны орлогоор буцаагаад зээлээ гэдэг юм уу, зээлийн хүүгээ төлөөд явах ёстой байхгүй юу. Нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС 2 бол яг ийм зүйл болчихсон. Дуусаагүй үйлдвэрлэлд авсан зээлдээ хүү төлөөд байгаа. Авч чадаагүй байгаа зээлдээ болохоор зэрэг аваагүйн төлөөх шимтгэл төлөөд байгаа. Өнөө анх авсан нэн хөнгөлөлттэй зээлийн ангилал алдагдах гээд байгаа.

Н.Наранбаатар: Дахиад 1 минут нэмж авах уу. Дахиад 1 нэмчихье. Ингээд 2 тодруулгаа авчихлаа шүү.

Ж.Батжаргал: Энэ жил гэхэд 113 тэрбум төгрөгийг бид авах ёстой зээлийнхээ аваагүй үлдэгдлийн төлөө шимтгэл төлж байгаа байхгүй юу. Энэ чинь бараг 640 хүүхдийн сургууль 8-ыг барих мөнгө шүү дээ. Тэгэхээр үүнийг аль болохоор хурдан дуусгаад, тэгээд өөрийнх нь орлого ашгаар нь тэр зээлийн хүүг нь төлж явах ёстой юм. Энэ бол бизнесийн зөв зарчим, удирдлага. Одоо үүнээс хойш хэдүүлээ юмнуудыг харин гэрээ соёрхон батлахдаа хамгийн зөв зүйлдээ авч байна уу, үгүй юу гэдгээ нарийн харж, зөв шийдлээ гаргадаг байх ёстой. Авчихсан бол маш богино хугацаанд авч ашиглаад үр өгөөжөөр нь тэр зээл, хүүгээ төлдөг юм руугаа орохгүй бол энэ чинь идэвхгүй ашигласныхаа төлөө баахан төлбөр төлөөд, зээлийнхээ өртгийг өндөржүүлээд байна шүү дээ.

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Яах вэ, энэ төсвийн хүрээ батлахын тулд бид нар дагаж байгаа хуулиудаа баталж байж төсвийн хүрээнийхээ орлого, зарлагын үзүүлэлтүүдийг чинь батлахгүй бол болохгүй. Тийм учраас энийгээ нэг мөр шийдээд явах ёстой. Ер нь бол энэ чинь нөгөө дэд заалтуудыг л хасалтыг нь орхигдуулчихсан байгаад байгаа шүү дээ. Эхний заалттайгаа бол ижилхэн. Тийм биз дээ. Тэгэхээр зүгээр энийг тийм тайлбар маягаар ойлгоод явчхаж болдоггүй юм уу. Найруулгын л асуудал болчихоод байна шүү дээ. Сая тэгээд 1 заалт нь тэгээд алга болчихоор тэгээд харин болох юм биш үү. Алга болж өгөхгүй байгаад байгаа юм уу. Үгүй ээ, тэгээд тэрийгээ протоколдоо тусгаад энэ бол энэ агуулгаар хасагдаж байгаа гэдгийг нь л тодруулаад явчхаж болдоггүй юм уу. Тэгэхгүй гэхээр чинь наадах чинь дахиад өргөн бариад гээд явах юм бол бид нар төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг энэ өөрчлөлтгүйгээр баталж болохгүй шүү дээ. Төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл дагасан хуулиудын өөрчлөлт заавал хийгдэж байж одоо мөрдөгдөж байгаа хууль

дээр хийгдэх ёстой байхгүй юу. Тийм учраас наад асуудлаа шийдээд, нэгэнт сая бол орж ирснийг бид нар дэмжчихлээ шүү дээ. Тэгэхээр та нар хуулийнхнаасаа нөгөө дүгнэлтээ, зөвлөмжөө гаргуулаад тэгээд гараад явах найруулгын өөрчлөлтүүдээ зохицуулах юмнуудыг нь хараач.

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрүүтэй санал энэ 2 дугаар зүйлтэй холбоотой байхгүй байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 1 зүйлтэй. Төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүн, Даваасүрэн гишүүнээр тасаллаа.

Г.Уянгахишиг: Энэ дээр би төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуумаар байгаа юм. Одоо энэ дээр бид нар яг 7.5 дугаар зүйлд маань юу гэж байгаа вэ гэхээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш 3-аас доошгүй сарын хугацаанд харгалзах тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх батлахыг хориглоно гээд энэ маш чухал заалт байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол бид нар төсвийн хүрээний мэдэгдлийн нэмэлт, өөрчлөлттэй гэдгийг нь хасчихаар нөгөө төсвийн хүрээний мэдэгдлээ бид нар ингээд юу гэдэг юм 7 хоног болгон эсвэл сар болгон өөрчлөөд байх боломжтой болох гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ хориглосон заалтад орохгүй болно гэсэн үг. Тэгээд дараагийнх нь тухайн жилийн төсвийн төсөл өргөн мэдүүлэх батлахыг, тэгэнгүүт төсвийн тодотголоо бас байн байн оруулаад байх боломжтой болчхож байгаа байхгүй юу. Уг нь энэ чинь ядаж 3 сарын хугацаанд энийгээ өөрчлөөд баймааргүй байна гэдэг ийм гол заалт байгаа байдаг. Тэгэнгүүт энд яг энэ төсвийн хүрээний мэдэгдлийн нэмэлт, өөрчлөлтийг гэдгийг нь хасаж байгаа гэсэн үг. Төсвийн тодотголын төслийг гэдгийг нь хасаж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ дээр үүсэх үр дагаврыг бол би яг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бүр тайлбарыг нь авмаар байна.

Н.Наранбаатар: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. 3 номер.

Ж.Дэлгэрсайхан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Дэлгэрсайхан. Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Бид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн барьсан болон дагалдах хуулиудтай холбоотой дүгнэлтээ өгсөн.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-д оруулж байгаа энэ төсвийн хүрээний мэдэгдлийн нэмэлт, өөрчлөлт болон тодотгол гэсэн 2 үгийг авч хаяснаараа бол энэ хуулийн заалт ерөөсөө маш хүчтэй суларна гэж үзэж байгаа юм. Учир нь өнөөдөр бид нар төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэхэд ашигладаг бодлогын баримт бичиг. Төсвийн хүрээний мэдэгдлийг тогтвортой байлгах энэ заалт дөнгөж түрүү жилээс хүчин төгөлдөр болж эхэлсэн. Хүчин төгөлдөр болонгуутаа энэ заалтыг бид хөндсөн. Түрүү жилийн 7 сард орж ирсэн төсвийн өөрчлөлтөөр бол 1 удаагийн шинж чанартай хуулиар 11 сарын 15 хүртэл энийг өөрчлөөд бид нар дөнгөж дуусаж байгаа юм. Тэгэхээр энэ

хууль ерөөсөө үйлчилж амжилгүйгээр ингээд өөрчлөгдөөд, хүчин чадал нь сулрах гэж байгаа байдлыг бол манай зөвлөлийн зүгээс бол ухралт гэж үзсэн. Ийм зүйл заалтыг оруулах нь бол буруу юм гэж үзсэн. Үүнийхээ үндэслэлийг бид 2 хувилбараар тайлбарласан.

1 дүгээрт төсвийн тогтвортой байдлыг хангах гол бодлогын баримт бичгээ бид ингэж сулруулах юм бол дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг зүйл байгаад учир утгаа алдчихаж байгаа юм. Ядаж бид нар 3 сар, ядаж 1 жил энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээ алсын хараатай байж чадахгүй юм бол 3 жилийн энэ баримт бичгийг бичгийг батлаад байгаагийн учир шалтгаан бол үнэндээ бид зүгээр л нэг юм батлаад яваад байгаад л болно л доо.

2 дахь үндэслэл нь төсвийг тодотгоод бид нар үр ашгийг авчирсан уу гэдгийг зөвлөлийн зүгээс харсан. Сүүлийн 13 жилийн хугацаанд Монгол Улс 15 удаа төсвөө тодотгосон байдаг юм байна лээ. 15 удаа тодотгохдоо бид нар төсвийн орлогыг 3 их наядаар бууруулж, зарлагыг 7 их наядаар өсгөсөн. Харамсалтай нь зарлагын өсөлтийн тэр 7 их наяд гаруй төгрөгийн ерөнхийдөө 400 тэрбум нь хөрөнгө оруулалтын зардал руу шилжсэн бөгөөд бид ялангуяа 2016, 2020, 2024 онуудад урсгал зардлын хэт тэлэлтийг хийхийн тулд л бид тодотголыг хийсэн байна гэсэн ийм дүгнэлтийг бид хийсэн юм.

Тийм учраас бидний зүгээс хүсэж байгаа гол зүйл бол төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах тусгай шаардлагыг нь сулруулах, тэгээд бодлогын баримт бичгийн үйлчлэлийг сулруулах ийм зүйлийг бол бидний хувьд төсвийн тогтвортой байдлын зүгээс бол битгий хийгээч л гэсэн ийм л хүсэлт байгаа юм. Баярлалаа.

Н.Наранбаатар: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Төсвийн тодотголыг дураараа хийдэггүй. Хуульд заасан төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг барьж байдаг. Тэр нөхцөлүүд нь үйлчлэх бололцоогүй болсон. Гэнэтийн гадаад орчин үүсэж болно, дайн дажин үүсэж болно, өвчин тахал үүсэж болно, төсвийн орлого огцом тасарч болно, зардал огцом нэмэгдэж болно. Энэ үед төсвийн тодотголыг хурдтай шуурхай хийх нь улс оронд хэрэгтэй. Тэгэхээр одоо бол төсвийн тодотгол болон төсвийг 3 сараар хязгаарлачхаад байгаа байхгүй юу. Тэгэхээрээ тодотголыг бол нөхцөл үүссэн үед яаралтай хийдэг хариу арга хэмжээг хурдан авах ёстой. Төсөв бол яг 3 сараа бариад явах ёстой. Төсөв, тодотгол гэдэг хуулийг нь 3 сараар хөдөлгөөн хийхийг хязгаарлачихсан байгаа нь нөхцөл байдал хүндэрсэн үед бол хариу арга хэмжээ авах чадавхаа Засгийн газар алдчихаж байгаа юм. Тэгээд эдийн засаг хүндрэх улам алдагдал буюу улам өөрчлөлт үнэ цэнтэй болдог руугаа л орно шүү дээ. Тэгэхээр гадаад орчны өөрчлөлт хүнд хүнд юм их гараад байна шүү дээ. Гэнэтийн дайн дажин, хямрал, нефтийн өсөлт, өвчин тахал юу эс үүсэх. Энэ үед л хариу арга хэмжээг хурдтай авах тэр орон зайг нь засагт гаргаж өгөөч ээ. Жишээлбэл, бид нар тэнцэл дээр 1,4 их наядын хасахтай яваад байна шүү дээ. Гэхдээ энэ чинь 2 сар, 3 сарын дүн бол 1,4 хадгалж аваад, 4 сар луу 1, 4-өөр л байгаад байна гэдэг чинь алдагдал нэмэгдэхгүй, төсвийн орлого сайжраад байна гэсэн үг байхгүй юу. Хаврын хамгийн их зардал гарч байгааг бүрэн санхүүжүүлээд, алдагдлыг нь бариад л байна. Экспорт бас нэмэгдээд байгаа нь үүнтэй холбоотой. Гэхдээ бас асуудлууд байна. Юу үүсэж магадгүй. Энэ шатахууны асуудал, ахиад энэ Ираны асуудал ахиад хурцдаад, одоо цохилт өгнө гэдгээ яриад, цаг хугацаа болзол тавьчхаад сууж байна. Ахиад энэ баррель нефть чинь 130-аас дээшээ 150 ороод ирэх юм бол дагаад л үнэ ороод ирнэ, валютын нөөц дээр дарамт бий болно.

200 сая доллар шилжүүлдэг байсан бол бид нар 400, 500 сая доллар шилжүүлдэг болоод л ирнэ шүү дээ. Тэр чинь гадаад улсын нөөцөд .../минут дуусав/

Н.Наранбаатар: Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Энэ тайлбар бас арай биш байна. Одоо жишээлбэл дайн дажин болдог юм уу ийм асуудал боллоо, гэнэтийн асуудал боллоо гэхэд бид нар хуулийн зохицуулалттай. Онцгой байдлын хуулийн зохицуулалт байгаа шүү дээ. Тэгэхээр одоо яг тэрийгээ тусад нь оруулаач ээ. Яг энэ заалт дээр бид нар бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөө дүгнэлтийг бид нар маш сайн харах ёстой. Юун төлөө энэ чинь Их Хурал дэргэдээ ийм зөвлөхүүдийн байгууллагатай билээ. Мэргэжилтнүүдээ цуглуулаад байлгаж байгаа билээ. Тэгэхээр нөгөө талаасаа яг энэ хуулийг хэлэлцээд батлаад ингээд явах үед ямар яриа гарсан бэ. Яагаад энэ тогтвортой байх ёстой байсан бэ. Энэ чинь 3 сар шүү дээ. Тэгээд дээрээс нь яг ингээд Засгийн газрын хийж байгаа төлөвлөгөөнүүд жишээлбэл 4 жилийн төлөвлөгөө гарч байна, 5 жилийн төлөвлөгөө, хөтөлбөр, чиглэл гарч байна. Тэр дотроо жил болгон төлөвлөгөө яригдаж байна. Тэгээд төсвөө баталж байна. Тэгээд төсвийн хүрээний мэдэгдлээ 3 жилээр гаргаж байна. Гэтэл энэ болгоныг чинь төлөвлөөд гаргаад явчхаж чаддаггүй юм уу. Одоо ингээд жишээлбэл юу гэдэг юм дурын хувийн одоо юу гэдэг юм гэр бүл байлаа эсвэл аж ахуйн нэгж байлаа тэр чинь төлөвлөгөөгөө гаргаад явдаг шүү дээ. Хөндлөнгөөс ийм нөхцөл байдлууд үүсэх гээд байна гээд, тэрийгээ хараад явдаг шүү дээ. Тэгээд зардлаа танадаг шүү дээ. Тэгээд Consistency plan гэж бас байна. Өөрөөр хэлбэл нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд энийгээ цаашаагаа яаж аваад явах вэ гэдгээ боддог шүү дээ. Тооцоолдог шүү дээ. Тэрнээс энэ бүх арга хэрэгслүүд нь байна. Хуулиараа зохицуулагдчихсан байна. Тэгэнгүүт төсвийн хүрээний мэдэгдлээ 3 жилээр гаргачхаад, яг тэр жилдээ төсвөө батлах болохоороо төсвийн хүрээний мэдэгдлээ дахиад өөрчилдөг. Үгүй ээ, тэр төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг чинь яг төсөвтэйгөө адилхан гарах ёстой юм уу. Анхнаасаа. Тэгээд энэ болгоныгоо яагаад хийж болдоггүй юм бэ. Би бол энэ дээр маш гайхаж явдаг юм угаасаа. Тэгээд яг одоо энэ асуудал ингээд ороод ирэхээр тайлбар бол бас тийм ойлгомжтой биш л байна.

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Үгүй ээ, одоо би энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Эдийн засгийн яам, Сангийн яам эд нарт нэг зүйл хэлээд байгаа юм. Хэдүүлээ тус тусдаа хууль, онол яриад суугаад байж болно. Бид тусгаар тогтносон 1 улс оронд энэ улсын хөгжлийг хангах гэж яваа хүмүүс шүү. Тийм учраас энэ гарч байгаа хууль тогтоомж юмнууд нь яавал хамгийн зөв, нийцтэй байх юм бэ гэдгийг бөөндөө сууж байж зөв шийдэл олох ёстой. Энэ тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа саналыг би дэмжиж байгаа.

Төсвийн тодотгол ямар нөхцөл байдал үүсэхээр хийдэг юм гэдгээ бид хэд Төсвийн тогтвортой байдлынхаа тухай хуульд тусгай шаардлага тавьчихсан шүү дээ. Тэр нь үүсчихсэн л юм бол хийхээс яах юм. Тэрийг хийхгүй хэвтээд байх юм бол наад улс чинь мөлхдөг юм байгаа биз дээ. Тэгээд мөлхүүлэхгүйн тулд бид төсвийн хүрээнд нь өөрчлөлт хийхээс яах юм. Бид хэд чинь бол орлого, зарлага хоёроо тоогоор тавьчхаад байгаа улс байхгүй юу. Тэрнээс хувиар биш. ДНБ-ий тэдэн хувь энэ тэр гээд тавьчихсан бол байгаад байж болохсон. Гэтэл бид хэд абсолют тоогоор тавьчхаад байгаа улс байхгүй юу. Тэр тоо өөрчлөгдөхөөр бид төсвийн хүрээг өөрчлөхөөс өөр арга байхгүй шүү дээ. Тэгэхээр ийм мунхаглалаас одоо гарцгаах ёстой. Тийм учраас би энийг бол харин дэмжиж байгаа. Одоо ийм юм

янз бүрийн цоож хуульд хийж болохгүй. Төсвийн тодотголыг ямар үед хийх вэ гэдэг юмаа л харин илүү тодорхой болгож өгөх ёстой. Тэр нөхцөл нь бий болчихсон бол 1 өдөр ч ухрааж таарахгүй. Үүнээс чинь болоод энэ улс орны эдийн засаг элгээрээ хэвтэнэ. Тэрний хор нөлөөг иргэд үүрэх болно. Тэрнээс биш хэдэн төрийн албан хаагч, хэдэн эрдэмтэд үүрэхгүй. Тийм учраас одоо хэдүүлээ жоохон ухаалаг байцгаая. Энэ төсвийн хүрээ чинь бол хамгийн гол нь ДНБ-ий тэдэн хувьд энэ тэр гээд бүх тоо тийм юутай байгаа бол болж байна. Хөдөлгөхгүй байж болж байна. Гэтэл бид орлого талаа хамгийн бага нь энэ байна. Зарлага талаа хамгийн дээд тал нь энэ байна гээд абсолют тоо тавьчхаад байгаа улс байхгүй юу. Тэгэхээр тэр чинь хөдөлж байгаа тохиолдолд бид хүрээнд хөдлөл хийхээс яах юм. Тэгэхээр энийг бол Их Хурлын гишүүд ээ, дэмжихээс өөр арга байхгүй.

Харин хамгийн гол нь энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дотор төсвийн тодотгол хийх нөхцөл үүссэн гэдэг юмаа л их зөв болгож өгөх ёстой. Тэрнээс биш үүнийг өөрчилж болдог юм гээд нэг өөр тоо хөдөлгөх гээд төсвийн тодотгол хийе гэж орж ирдэг байж таарахгүй. Төсвийн орлого нь хэдэн хувиар тасарчхаад байгаа гэдэг юм уу, тэр нь он дуустал яг хадгалагдахаар байгаа нөхцөл үүсчихсэн гэдэг юм уу, энэ юмнуудаа харж, харин тэр төсвийн тодотгол хийх тусгай шаардлага бол харин их илүү .../минут дуусав/

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Даваасүрэн гишүүн асуулт асууя.

Ц.Даваасүрэн: Бид 1 буруу ойлголттой яваад байгаа юм. Төсвийн алдагдал энэ тодотгол хийнэ гэдэг юм их аюултай юм шиг ингээд ойлгоод байгаа юм. Энэ тийм зүйл бас биш ээ. Одоо жишээлбэл Австрали, Шинэ Зеланд, Европын орнууд бол төсвийн тодотголыг тухай бүрд нь хийгээд л явдаг. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг Тогтвортой байдлын тухай хууль гэдэг юм чинь 2000 оны эхээр төсвийн нөхцөл байдал хүнд Валютын сангийн хөтөлбөрт хамрагдаж байх хугацаанд бидний үүрэг хүлээж авсан арга хэмжээ байхгүй юу. Тэгэхээр энэндээ одоо болтол ингээд баригдаад яваад байх уу. Зарим чиглэлд нь өөрчлөлт хийх үү гэх ийм цаг хугацааны хувьд бол бас шаардлага үүсчихсэн байж магадгүй. Үгүй ээ, бид нар үнэхээр хүнд нөхцөл байдал үүсэх юм бол төсвийн тодотгол хийхгүй гээд суугаад байж болохгүй шүү дээ. Одоо шатахууны үнэ хэд ч хүрэх юм билээ. Байгаль, цаг уурын хүнд нөхцөл байдал үүсэж болно. Тийм учраас зарим нэг хүлээснүүдийг одоо болиод, би бол төсвийн хүрээний мэдэгдэл гэдгийг яг барьж байна уу, үгүй юу, бид нар хэрэгжүүлж байна уу, үгүй юу гэдгээ бодох цаг болсон.

Миний зүгээр гол анхаарах ёстой юм бол өр гэж бодоод байгаа юм. Алдагдалтай байж болно. Тэгэхдээ өрийн дарамтад орохгүй хэмжээнд зээллэгээ хийдэг л байх ёстой байхгүй юу. Тэгээд өрөө л хянаад явах ёстой. Харин саяын энэ юун дээр бол өрийн хэмжээг бол айхтар өсгөсөн байна лээ. Тэрийг бид нар анхаарах хэрэгтэй. 2025 онд бол бид нар Засгийн газрын өр 39 их наяд байгаа байхгүй юу. 2027 онд 57 их наяд буюу 17 их наядаар 5 тэрбум доллароор Засгийн газрын зээлийг өсгөнө гэж байгаа чинь харин байж болохгүй зүйл байхгүй юу. Энийг л бид нар харах ёстой. Төсвөө алдагдаад хэлэхдээ өр үүсгэж санхүүжүүлж байна уу гэдгийг л хар. Тийм учраас одоо тодотгол хийнэ, хийхгүй гэдэг алдагдалтай, алдагдалгүй байна гэдэг бол гол асуудал биш. Өрөнд орохгүй байна гэдэг нь л хамгийн гол асуудал байхгүй юу. Тийм учраас цаашдаа бид нар өр нь төсвийн энэ асуудал дээрээ өөрчлөлт хийгээд, өрийн хяналтуудаа л чангалаад явах асуудал нь л хамгийн чухал байж магадгүй гэж би бодоод байгаа юм. Тийм учраас би одоогийн орж ирж байгаа энэ асуудлыг шийдээд явчихад бол болохгүй юм байхгүй байх.

Харин бид нар энэ төсвийн хүрээний мэдэгдлийг батлахдаа яагаад 17 их наядаар зээл авах гээд байгаа юм бэ. 1 жилийн дотор, 2 жилийн дотор гэдгийг харин ярих ёстой байхгүй юу. 5 тэрбум долларын зээл авах гээд байна шүү дээ. Энэ чинь ерөнд оруулж магадгүй. Энэ мэтийн юмаа л анхаарах ёстой байх гэж би бодоод байгаа юм.

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Би энийг бас дэмжиж байгаа юм. Тэгэхгүй бол бид нар өмнө нь ажлын хэсэг гаргаад, нам намын төлөөллөөс ороод ажиллахад төсвийн тодотголыг бол угаасаа Төсвийн тухай хуулийн дагуу, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсвийн орлого урьдчилан тооцоолох нөхцөл боломжгүйгээс төсвийн орлого тасрах, буурах, зарлага огцом нэмэгдэх, үүнээс үүдээд алдагдал ихсэх ийм тохиолдолд л хийдэг угаасаа хуулиараа. Ингээд хэрвээ энэ 3 сарын хүлээсийг авахгүй бол би тооцож үзсэн чинь ингэж байна лээ. Байнгын хорооны гишүүд ээ, өнөөдөр төсөв тодотгохоос өөр аргагүй нөхцөл байдал үүслээ гэе. Тэгвэл 3 сарын дараагаас эхлээд төсвийн хүрээгээ батлуулна. Төсвийн хүрээг хамаг хурдаараа боловсруулаад Улсын Их Хурлаар хэлэлцүүлээ гэхэд 1 сар бараг 3 долоо хоног багадаа болох байх тийм ээ. Тэгээд үүний дараа төсвийн хүрээгээ батлуулсны дараа дахиад төсвийн тодотголоо хүрээнийхээ хэмжээнд оруулаад өргөн барихад ахиад хамаг хурдаараа Улсын Их Хурлаар хэлэлцүүлээ гэхэд 3 долоо хоног болно. Ингээд төсөв тодотгох, өөрөөр хэлбэл орлого тасрах, эсвэл зардал ихсэх бид нарын урьдчилан тооцоолох аргагүй нөхцөл байдлаас үүдээд төсвийн тодотгол хийхэд дор хаяж 4 сар хагасын дараа бид нар зарлагаа бууруулах, эсвэл орлогоо нэмэгдүүлэх байдаг юм уу ийм нөхцөл байдал үүснэ гэсэн үг. Тэр 4 сар хагасын дотор өмнөх баталсан төсвөөрөө Засгийн газар ажиллахаас өөр аргагүй болно. Цалингаа байдаг юм уу, зарлагаа бууруулах арга хэмжээ авч чадахгүй. Энэ чинь хууль юм чинь түүгээрээ л явна. Тэгэхээр энэ хооронд зарлага нь огцом нэмэгдээд, ингэж явсаар байгаад төсөв улам хүндрээд, 4 сар хагасын дараа бол бараг тодотгоод ч хэрэггүй нөхцөл байдал үүснэ.

Ихэнхдээ жилийн дундуур бид нар 4, 5, 6 сараас л ер нь нөхцөл байдлыг харж байж эдийн засаг хүндрэх юм бол тодотголын асуудал яригдана. Ингээд одоогийнхоор бол бараг дараа жилийнхээ төсөвтэй хамтдаа хэлэлцэж, тухайн жилийн төсөвт тодотгол хийх нөхцөл байдал үүснэ гэсэн үг. Тэгэхээр эдийн засаг улам л хүндрээд, нөгөө анхны баталсан орлогоороо, анхны баталсан өндөр зарлагаараа явахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсэх учраас үүний бол хуулийг нь дэмжих нь зүйтэй гэж үзэж байна. Тэгж байж тодотгол бол угаасаа л хуулийн дагуу маш хүнд нөхцөл байдалд тодотгол хийдэг юм чинь үүнээс өөр аргагүй гэж бодож байна.

Н.Наранбаатар: Жавхлан гишүүн асуулт асууна.

Б.Жавхлан: Энэ хуулийн төслийг дэмжинэ. Энэ хуулийг дэмжсэнээр төсвийн сахилга бат алдагдана гэж хүмүүс ярьдаг юм. Харин эсрэгээрээ харин ч төсвийг сайжруулах, Энхбаяр сайдын хэлж байгаагаар хариу үйлдэл хийх ийм боломжоор хангаснаар дунд, урт хугацаанд эдийн засаг өөрөө тогтвортой явах энэ боломжийг хангадаг. Эцсийн дүндээ оруулж ирж байгаа тодотголыг Их Хурал л батална шүү дээ. Бид л батална.

2 дугаарт яг тэр учир шалтгааныг нь бол Батжаргал гишүүн яг хэлчихлээ дээ. Төсвийн тухай хуулийн 34.1.2 дээр ямар тохиолдолд төсвийн тодотгол хийх вэ гэдэг

тусгай шаардлагуудыг нь заачихсан байгаа. Тэр 5 заалт байдаг. Тусгай шаардлага хангах боломжгүй болсон, төсвийн алдагдал 3 хувиас дээш нэмэгдэхээр болсон, өртөг нэмэгдэхээр болсон, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зохицуулалт хийх болсон, аль эсвэл Засгийн газар деполт зарлах болсон ийм тохиолдолд л тодотгол хийнэ гээд зарлачихсан. Хуулиараа заачихсан. Гэтэл энэ тохиолдлууд нь үүсчхээд байхад үгүй ээ, болохгүй, 3 сарын дотор тодотгол хийж болохгүй гэж суух 1 өдөр ч гэсэн үнэтэй байдаг байхгүй юу. Төсвийн хүрээ одоо цаглавраа харъя. 5 сарын 31-нд төсвийн хүрээ батлагдах ёстой. Чуулган 7 сарын 1-нд завсарладаг. 3 сар болоогүй байна гээд 7 сарын 1 хүргэчихнэ. Тэгээд 10 сарын 1 хүртэл чуулган хуралдахгүй. Энэ хооронд чинь Монголын эдийн засаг битгий хэл дэлхий өөрөө эргэх хугацаа байхгүй юу. Тийм учраас ийм тусгай шаардлагуудыг нь зааж өгчхөөд, нөгөө талд нь тусгай шаардлага нь үүсчхээд байхад тодотгол хийж болохгүй гэж ингэж хайчин дотор оруулж болохгүй юм. Ийм төсвийн зохицуулалттай улс орон гэж ер нь өөр хаана байдгийг сайн хэлж мэдэхгүй байна.

Тэгэхээр Тогтвортой байдлын зөвлөлийн зовлонг ойлгож байна. Та бүхний эрсдэл талаас нь харж байгааг чинь бас ойлгож байна. Гэхдээ саяын миний хэлсэн өнцгийг нэг хараарай Дэлгэрсайхан багшаа. Тусгай шаардлагууд нь биелчхээд бүр балрах гээд байхад та нар болохгүй гээд ингээд дараад хэвтээд байж бас болохгүй байхгүй юу. Тэр хороонд чинь муужраад уначихна шүү дээ. Саяын таны хэлж байгаа 15 тодотголын чинь сүүлийн 5, 6 тодотгол нь бол миний үед Сангийн сайд хийж байх үед хийсэн тодотголууд байгаа. Энэ бол бид нар гадна талдаа хилээ хаалгачихсан, дотор талдаа хөл хоригдчихсон үед төсвийн алдагдал өнөөдрийнх шиг 1,5 биш, 8 хувь хүрч байсан үе шүү дээ. 2023 оны 1 сард Казакстанд юу боллоо. Дараа нь дайн юу боллоо. Ийм үед төсөв 1, 2 дахь асуудал, Монголын иргэдийн амь насны асуудал 1 дүгээр асуудал байдаг байсан гэх мэт амьдрал өөрөө баян. Юу ч тохиолдохыг үгүйсгэхгүй. Гэхдээ тусгай шаардлага үүссэн тохиолдолд .../минут дуусав/

Н.Наранбаатар: Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. 1 зарчмын зөрүүтэй санал ирсэн. 2 ирсэн байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

1.Хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмсүгэй:

"1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн "мэдэгдэл, түүний нэмэлт өөрчлөлтийг" гэснийг "мэдэгдлийг" гэж өөрчилсүгэй." Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад бэлтгэсэн үү. Санал хураалтад бэлтгээрэй. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 44.1 хувиар дэмжигдсэнгүй.

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн "7.5 дахь хэсгийн "түүний нэмэлт, өөрчлөлтийг", "төсвийн тодотголын" гэснийг тус тус хассугай" гэснийг "7.5 дахь хэсгийн "төсөл, төсвийн тодотголын" гэснийг хассугай" гэж өөрчилж, мөн зүйлийн дугаарыг "2" гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. 41.2 хувиар дэмжигдсэнгүй. Төслөөрөө үлдлээ. Найруулгын л юм байгаа. Уг нь зөв болгоод явчихъя гэж л оруулсан юм. Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн

засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Батчимэг гишүүн танилцуулах уу. Өөр Батбол санал, дүгнэлт танилцуулах уу чуулганд. Улсын Их Хурлын гишүүн Батболд танилцуулна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан дууслаа. Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа.

Саяын санал дээр Эрдэнэбат гишүүнийг дэмжсэнээр аваарай. Протоколд тусгаарай.

14.00 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ